



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



БИЧИЛ УУРХАЙЧДЫН БИЗНЕС ЭРХЛЭЛТ БА ОРОН НУТАГТ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Сайн туршлагууд



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

БИЧИЛ УУРХАЙЧДЫН БИЗНЕС ЭРХЛЭЛТ БА ОРОН НУТАГТ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

/Сайн туршлагууд/

2016 он

ДАА 622
ННА 33
Б-505

Бичил уурхайчдын бизнес эрхлэлт ба орон нутагт
оруулж буй хувь нэмэр
/Сайн туршлагууд/

Боловсруулсан: П.Амармэнд, Ө.Батсайхан

Хянан тохиолдуулсан: Д.Энхболдбаатар

©Бүх эрхийг Швейцарийн Хөгжлийн Агентлагийн "Тогтвортой бичил уурхай" төсөл эзэмшинэ.

ISBN 978-99978-4-194-0

ГАРЧИГ

Товчилсон үгс	5
Оршил	6
БАЯН БӨМБӨГӨР ТББ	8
"Уран гар" оёдлын цех	8
Мөнгөн хуримтлалын бүлэг	9
Орон нутагт оруулж буй хувь нэмэр	11
Ирээдүйн төлөвлөгөө	11
ТББ-ын танилцуулга	12
ӨЛЗИЙТ ХИШИГ БУЯН ТББ	14
Орон нутагт оруулж буй хувь нэмэр	14
Ирээдүйн төлөвлөгөө	15
ТББ-ын танилцуулга	15
ТАХИЛГАТ ЛУСЫН БУЛАГ ТББ	18
Бизнесийн бусад үйл ажиллагаа	18
Орон нутагт оруулж буй хувь нэмэр	19
Ирээдүйн төлөвлөгөө	20
ТББ-ын танилцуулга	20
ГУРВАН БУХТЫН ТОЛГОД ТББ	22
Бизнесийн бусад үйл ажиллагаа	22
Орон нутагт оруулж буй хувь нэмэр	22
Ирээдүйн төлөвлөгөө	24
ТББ-ын танилцуулга	24
ХУВИАРАА АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОГЧДЫГ ДЭМЖИХ ХОЛБОО ТББ	26
Бизнесийн бусад үйл ажиллагаа	26
Орон нутагт оруулж буй хувь нэмэр	27
Ирээдүйн төлөвлөгөө	29
ТББ-ын танилцуулга	29
БАЯНГОЛ БАЯСГАЛАНТ ХАЙРХАН ТББ	31
"Ажилсаг арван хуруу" төсөл буюу ажлын бээлийний цех	31

Орон нутагт оруулж буй хувь нэмэр	32
Ирээдүйн төлөвлөгөө	32
ТББ-ын танилцуулга	32
ЦАНЧИР БАЯНБУЛАГ ТББ	34
Төмс, хүнсний ногооны тариалан	34
Эсгий эдлэлийн гар үйлдвэр	34
Сэргээн засах эмнэлэг	35
Ирээдүйн төлөвлөгөө	36
ТББ-ын танилцуулга	36
ДУУШ МАНДАЛ ХАЙРХАН ХОЛБОО ТББ	37
Явган замын хавтан, блокны үйлдвэр	37
Орон нутагт оруулж буй хувь нэмэр	38
Ирээдүйн төлөвлөгөө	39
ТББ-ын танилцуулга	40
ЭВСЭГ ТУУЛЫН ГҮҮР ТББ	41
Гахайн аж ахуй	41
Ирээдүйн төлөвлөгөө	45
ЗААМАР НУТГИЙН ХӨГЖИЛД БИДНИЙ ОРОЛЦОО ТББ	47
Төмс, хүнсний ногооны тариалан	47
Орон нутагт оруулж буй хувь нэмэр	47
Ирээдүйн төлөвлөгөө	48
ТББ-ын танилцуулга	48
ЭХ ОРОН ХАМТЫН ХҮЧ ТББ	50
Бизнесийн бусад үйл ажиллагаа	50
Орон нутагт оруулж буй хувь нэмэр	50
Ирээдүйн төлөвлөгөө	52
ТББ-ын танилцуулга	52
БАЯН РАШААНТ НУТАГ ТББ	56
"Ариун эрдэнэ солонго" ХЗХ	56
Орон нутагт оруулж буй хувь нэмэр	57
Ирээдүйн төлөвлөгөө	58
ТББ-ын танилцуулга	59

ТОВЧИЛСОН ҮГС

АМГ	Ашигт малтмалын газар
БОХТОН-II	Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь II
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МБУНДХ	Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо
НД	Нийгмийн даатгал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТБУТ	Тогтвортой бичил уурхай төсөл
ТББ	Төрийн бус байгууллага
УЗ	Удирдах зөвлөл
УБЕГ	Улсын Бүртгэлийн ерөнхий газар
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо
ХАМО	Хувиараа ашигт малтмал олборлогч
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ХЗ	Хяналтын зөвлөл
ШХА	Шейцарийн хөгжлийн агентлаг
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

ОРШИЛ

Монгол улсад бичил уурхайн үйл ажиллагаа хууль, эрх зүйн зохицуулалттай болж, бичил уурхайчид олборлолтоо албан ёсоор эрхлэх болсоор багагүй хугацаа өнгөрч байна. Өнөөдөр бичил уурхайчид, тэдний ТББ-ууд олборлох үйл ажиллагаанаасаа гадна орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх, амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор хоршоо, нөхөрлөл, компанийн хэлбэрээр болон хувиараа төрөл бүрийн жижиг, дунд бизнес эрхэлцгээх болжээ. Энэ нь орон нутгийн хөгжил, эдийн засагт оруулах тэдний хувь нэмрийг нэмэгдүүлж буй нэг арга зам болж байна.

Бичил уурхайчид хамтран жижиг бизнес эрхлэхийг ТБУТ-өөс дэмжсээр ирсэн бөгөөд ингэхдээ, орон нутгийн засаг захиргааны дэмжлэгийг авсан байх, аль болох олон бичил уурхайчин хамтарсан байх, бизнесийн үйл ажиллагаанд оролцож буй бичил уурхайчид өөрсдөө тэрхүү бизнестээ бодит, шууд хөрөнгө оруулалт хийсэн байх гэсэн гурван гол шалгуур тавьдаг. Шалгуур хангасан бизнест төслөөс санхүүгийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах дэмжлэг үзүүлдэг. Үүний дээр орон нутгийн удирдлагуудаас тухайн бизнесийг хөгжүүлэх таатай орчин, нөхцөлийг бүрүүлэхэд анхаарч, дэмжвэл уг бизнесийн үр дүн сайжирдаг жишиг байна.

Бичил уурхайчид уурхайгаас олсон орлогоороо өөр бусад жижиг, дунд бизнест хөрөнгө оруулалт хийх нь орлогын эх үүсвэрээ олон талтай, баталгаатай болгох, амьжиргаагаа дээшлүүлж, үр хүүхдийнхээ сурч, боловсрох нөхцөлийг сайжруулах шат ахисан чухал алхам юм. Бид энэхүү товхимолдоо тэдний жижиг, дунд бизнест оруулж байгаа хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг онцгойлон дурдахдаа, тухай тухайн бизнесээрээ сум орон нутгийнхаа эдийн засаг, бизнесийн хөгжилд хэрхэн хувь нэмэр болдог талаас нь өгүүлэхийг эрмэлзсэн юм.

Бичил уурхайчдын эрхэлж буй жижиг, дунд бизнесүүдийн ашиг, ажиллагсдын тоо, тогтвортой байдал нь сум орон нутаг бүрийн онцлог, зах зээл, хүн амын тоо, тухайн бизнесийг

эрхэлж буй буй хүний ур чадвар боломжоос хамааран янз бүр байгаа хэдий ч уурхайн бус аргаар тогтвортой, урт хугацааны амьжиргааны эх үүсвэртэй болох гэсэн нэг л хүсэл зорилгынх нь илэрхийлэл юм. Тухайлбал, зөвхөн энэ товхимолд орсон 12 ТББ-ын гишүүн бичил уурхайчид оёдлын цех, үнээний ферм, хүнсний дэлгүүр, зочид буудал, уламжлалт мал аж ахуй, зоогийн болон цайны газар, цахилгаан барааны дэлгүүр, ажлын бээлийний үйлдвэр, хүнсний ногооны тариалан, жижиг эсгий эдлэлийн цех, сэргээн засах эмнэлэг, явган замын болон хашааны бетон хавтан, блокны үйлдвэрлэл, гахайн аж ахуй, талх, нарийн боовны цех, үсчин, гоо сайхны үйлчилгээ, хадгаламж зээлийн хоршоо, өнгөт чулуу боловсруулах үйлдвэр зэрэг 20 нэр төрлийн бизнесийг эрхэлж байна.

Бичил уурхайчдын бизнесийн үүсэл, санаачилга, орон нутагтаа оруулж буй хувь нэмрийг сурталчлах, бусдад үлгэр дууриалал, санаа сэдэл болгох үүднээс энэхүү товхимлыг Тогтвортой бичил уурхай төслөөс хэвлэн гаргалаа.

БАЯН БӨМБӨГӨР ТББ

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Баян бөмбөгөр ТББ-ын гишүүн бичил уурхайчид “Уран гар” оёдлын цех, мөнгөн хуримтлалын гурван бүлэг байгуулан ажиллаж байна. 2015 онд



тус ТББ сум, орон нутгийн төсөвт 840.0 мянган төгрөгийн ХАОАТ төлжээ. Мөн сумынхаа тохижилтын болон цэвэрлэгээний зэрэг нийгэмд тустай ажлуудад идэвхтэй оролцож, хөрөнгө мөнгө, хүч хөдөлмөрөөрөө нутаг орныхоо хөгжилд хувь нэмэр оруулж байна.

“Уран гар” оёдлын цех

Баян бөмбөгөр ТББ-ын Ундрах нөхөрлөлийн гишүүд ТБУТ, нутгийн захиргааны дэмжлэгтэйгээр “Уран гар” оёдлын цех байгуулан ажиллаж байна.

Тус оёдлын цех сар бүр,

- гэрийн гадуур бүрээс 20 ширхэг,
- гэрийн цагаан цаваг /дотуур бүрээс/ 20 ширхэг,
- гэрийн хөшиг 15 ширхэг,

- хаяавч 10 ширхэг,
- гэрийн өрх 20 ширхэг,
- хаалганы дулаалга 10 ширхэг,
- хөнжлийн даавуу 40 ширхгийг

тус тус үйлдвэрлэн Бөмбөгөр сумын малчид, ард иргэдээс гадна Баянхонгор аймгийн төвийн зах, худалдааны төвүүдээр борлуулж байна.

Ундрах нөхөрлөлийнхөн оёдлын үйлдвэрлэлээ амжилттай явуулснаар нэг гишүүн сар бүр хамгийн багадаа 300.0 мянган төгрөгийн орлоготой болж, НД, ЭМД-аа тогтмол төлж, жилдээ бичил уурхайн бус арга замаар 3.6 сая төгрөгийн орлого олох тооцоотой ажиллаж байна. Мөн сар бүрийн тогтмол орлогоо баталгаажуулж явснаар тэтгэвэр тогтоолгох, банкнаас зээл авах нөхцөл бүрдэнэ.

Нөхөрлөлийн гишүүдийн хоёр нь эсгүүрчин, оёдолчны мэргэжилтэй, бусад нь мэргэжлийн үнэмлэхгүй хэдий ч үндэсний дээл хувцас оёж өрхийн хэрэгцээгээ хангаж ирсэн туршлагатай хүмүүс байгаа нь энэхүү төслийн амжилттай хэрэгжих үндэс болжээ.

Орон нутаг, ТБУТ-ийн дэмжлэг

“Уран гар” оёдлын цехийнхэн тоног төхөөрөмжөө ТБУТ-өөс олгосон 5.0 сая төгрөгийн санхүүжилтээр авчээ. Орон нутгийн удирдлагууд тэднийг дэмжин сумын ахуйн үйлчилгээний төвд 4хб хэмжээтэй үйлдвэрлэлээ явуулах байр гаргаж өгсөн байна. Харин эргэлтийн хөрөнгөө Ундрах нөхөрлөлийн гишүүд тус бүр 100.0 мянган төгрөг нийлүүлэн бүрдүүлж цехийнхээ үйл ажиллагааг эхлүүлжээ.

Мөнгөн хуримтлалын бүлгүүд

Бичил уурхайгаас олсон орлогоосоо хуримтлал үүсгэх, бүлгийн гишүүдийнхээ богино хугацааны санхүүгийн хэрэгцээг хангах зорилгоор Баян бөмбөгөр ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2015 оны аравдугаар сараас мөнгөн хуримтлалын гурван бүлэг байгуулан ажиллаж байна.

Чандмань эрдэнэ бүлэг

Нийт 18 хүнтэй Чандмань эрдэнэ бүлгийн ахлагч нь Ц. Наранцэцэг. Тус бүлэг одоогийн байдлаар нийт 1.3 сая төгрөг хуримтлуулж, түүнээсээ 12 хүнд 1,317,000 төгрөгийн зээл олгоод байна.

Буян хишиг бүлэг

Нийт 20 хүнтэй Буян хишиг бүлгийн ахлагч нь Ц. Эрдэнчимэг. Энэ бүлэг одоогийн байдлаар 1.7 сая төгрөг хуримтлуулж, түүнээсээ есөн хүнд 1,650,000 төгрөгийн зээл олгоод байна.

Буян арвижих бүлэг

Баян бөмбөгөр ТББ-д гишүүнчлэгдэн ажиллахын зэрэгцээ хөдөө мал малладаг 12 бичил уурхайчдаас бүрдсэн Буян арвижих бүлгийг Б. Энхболд ахалдаг. Энэ бүлэг одоогийн байдлаар 310.0 мянган төгрөгийн хуримтлал үүсгээд байгаа ба зээл олгож эхлээгүй байна.

Хуримтлалын бүлгүүдийн үйл ажиллагааны зарчим

Бүлгийн гишүүд сар бүрийн таван, 25-нд цуглан уулзаж дундын хуримтлалдаа мөнгө нийлүүлдэг. Нэг удаагийн уулзалтаар гишүүн бүр 2000 төгрөгөөс багагүй, 10 000 төгрөгөөс ихгүй хэмжээний мөнгө нийлүүлэн хуримтлуулж байхаар тохиролцсон байна. Мөн энэ үеэрээ зээлийн хэрэгцээ гарсан хэн нэгэндээ хуримтлалын сангаас мөнгө зээлүүлэх эсэхийг хэлэлцэн шийддэг.

Хуримтлалаасаа гишүүддээ сарын 5.0 хувийн хүүтэй зээлүүлдэг ба зээлийн дээд хэмжээ 300.0 мянган төгрөг, дээд хугацаа гурван сар байна. Эхний сар зөвхөн хүүгээ төлж, үлдсэн хоёр сард нь үндсэн төлбөрөө, хүүний хамт төлөх нөхцөл тавьдаг.

Хуримтлалын бүлгийн бэлэн мөнгийг хадгалах авдар нь гурван давхарцоожтой ба бүлгийн гурван өөр хүн түлхүүрүүдийг нэг нэгээр нь хадгалж, дөрөв дэх буюу түлхүүр хадгалж буй гурван хүнээс өөр нэг хүн авдрыг хадгална. Бүлгийн нарийн

бичгийн дарга бүх үйл ажиллагааг баримтжуулж, бүртгэл тооцоог хийж явдаг бол бүлгийн ахлагч, хурлын үйл ажиллагааг зохион байгуулдаг. Бүлэг хоёр мөнгө тоологчтой байдаг ба хуримтлуулсан болон зээлсэн бүх мөнгийг тоологч нар давхар тоолно. Бүлгийн гишүүдийн хуримтлуулсан мөнгийг хүн бүрээр тусад нь бүртгэх бөгөөд жилийн эцэст хуримтлалын бүлгийн нийт орлогыг тооцож, гишүүдийн оруулсан мөнгөний хувь хэмжээнд харгалзуулан ашгийг хуваарилдаг.

Орон нутагт оруулсан хувь нэмэр

ХАОАТ

2015 онд Баян бөмбөгөр ТББ-ын гишүүн бичил уурхайчид ХАОАТ-д нийт 840.0 мянган төгрөг төлсөн байна.

Нийгэмд тустай үйлс

Сум, орон нутагтаа зохион байгуулагдаж буй нийтийг хамарсан ажил, арга хэмжээнүүдэд Баян бөмбөгөр ТББ-ын гишүүд идэвхтэй оролцож, нутгийнхаа хөгжил дэвшилд хүч хөдөлмөрөөрөө хувь нэмэр оруулдаг. Тухайлбал,

1. Сумын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг 2015 онд ТББ-ын гишүүн 13 бичил уурхайчин үнэ төлбөргүй гүйцэтгэж өгсөн.
2. Волейболын элсэн талбайг ТББ-ын гишүүн таван бичил уурхайчин 2015 онд цалин хөлсгүй хийж өгсөн.
3. Жилд хоёр удаа болдог сумын нийтийн их цэвэрлэгээнд тус бүр 20 гаруй хүн оролцсон.
4. Бөмбөгөр сумын мод тарих аянд ТББ-ын гишүүд идэвхтэй оролцсон.
5. Сумын эмнэлгийн 90 жилийн ойн баяр наадам зохион байгуулахад 100.0 мянган төгрөг хандивласан.

Ирээдүйн төлөвлөгөө

Бичил уурхайчдын ТББ гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийг хамгаалж, тэдний дуу хоолойг орон нутгийн болон үндэсний төвшинд төлөөлөх, ажиллах нөхцөлийг хангаж, байгальд

ээлтэй, хариуцлагатай бичил уурхайг эрхлэх арга, боломжийг бүрдүүлэх, гишүүдийнхээ нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгыг үйл ажиллагааныхаа чиглэл болгодог.

2016 онд Баян бөмбөгөр ТББ Азийн сангийн БОХТОН-II төсөлд хамрагдахаар хүсэлт гаргахаар төлөвлөсөн бөгөөд үүнтэй холбогдуулан Бөмбөгөр сумын ИТХ-аас Өндөр толгой хэмээх газарт 4.0 га талбайд нөхөн сэргээлт хийх зөвшөөрөл олгож, ОНХС-гаас 4.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх шийдвэрлэсэн байна.

Цаашид Баян бөмбөгөр ТББ хуримтлалын бүлгүүдээ өргөжүүлэн Хадгаламж зээлийн хоршоо болгох, зөвхөн бичил уурхайчдаар хязгаарлагдахгүй Бөмбөгөр сумын ард иргэд, малчдаар гишүүнчлэлээ тэлж, хадгаламж зээлийн үйлчилгээ үзүүлэх зорилт тавин ажиллаж байна.

ТББ-ын танилцуулга

1999-2002 онуудад Бөмбөгөр суманд жил дамнан үргэлжилсэн ган, зудын хөлд нэрвэгдэн малчид олноороо малгүй болж, амьжиргааны эх үүсвэргүйн эрхээр хувиараа ашигт малтмал олборлож эхэлсэн юм. Анхандаа хувиараа ашигт малтмал олборлогч иргэд ямар ч зохион байгуулалтгүй, эмх цэгцгүй, замбараагүй ажиллаж, асар их эрсдэл, аюул осолтой байдалд олборлолт явуулж байсныг ШХА-ийн ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулсан юм. Ингэснээр тэд нийгмийн хариуцлагатай гишүүд болцгоож, холбогдох төрийн болон ТББ, бусад салбарын хамт олонтой хамтран ажиллах болсон юм. Улмаар хувиараа ашигт малтмал олборлогч /ХАМО/ гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилгоор 2008 оны 10 дугаар сард 27 нөхөрлөлийн 177 гишүүнтэйгээр Баян бөмбөгөр ТББ-ыг байгуулсан байна.

Өнөөдрийн байдлаар тус ТББ нь таван нөхөрлөлийн 45 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Нийт гишүүдийг хүйсийн хувьд авч үзвэл эрэгтэй гишүүд 15 буюу 33% нь, эмэгтэй гишүүд 30 буюу 67% нь байна. Нэг нөхөрлөлд таваас арван хүн хамрагдан үйл ажиллагаа явуулж байна.

Баян бөмбөгөр ТББ нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн сум, орон нутгийн захиргаатайгаа хоёрлосон гэрээ байгуулж, бичил уурхайн зориулалтаар олборлолтын газар авч ашиглан, олборлолтоо дуусгасны дараа нөхөн сэргээлт хийж хүлээлгэж өгч ирсэн туршлагатай. Үүнд,

1. 2008-2009 Буйлсан хэмээх газарт 4.0 га,
2. 2010 онд Өөхт хэмээх газарт 2.0 га,
3. 2011 онд Алаг толгой хэмээх газарт 1.0 га,
4. 2015 онд Өндөр толгой хэмээх газарт 2.0 га

талбайд тус тус олборлолт явуулж, нөхөн сэргээгээд байна.

Хамгийн сүүлд 2015 оны тавдугаар сарын 28-наас наймдугаар сарын 10-ны хооронд Өндөр толгойн талбайд ТББ-ын үндсэн 40 гишүүн, гишүүн бус 50 ХАМО иргэд түр нэгдэж, нийт 90 бичил уурхайчинтай ажиллажээ.

УЗ-ийн бүрэлдэхүүн

1. Г.Мөнхдалай
2. Д.Нэргүй
3. Ж.Саруул
4. Ц.Саранцэцэг
5. Л.Эрдэнэчимэг

ХЗ-ийн бүрэлдэхүүн

1. Т.Ганцоож
2. И.Гэрэлсүх
3. Н.Сувдмаа

Тэргүүн, гүйцэтгэх захирал: Ж.Саруул

ӨЛЗИЙТ ХИШИГ БУЯН ТББ

Дундговь аймгийн Өлзийт сумын Өлзийт хишиг буян ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2014, 2015 онуудад орон нутагтаа хандив тусламж, татвар, НД, ЭМД-ын хэлбэрээр 56.1 сая төгрөгийн хувь нэмэр оруулсан байна.

Тус ТББ-ын гишүүн бичил уурхайчид сар бүр хамгийн багадаа 1,080 тонн орчим жонш олборлож, жилдээ 648.0 сая төгрөгийн орлоготой ажиллан, сум орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулж байна.

Өлзийт хишиг буян ТББ-ын бичил уурхайчдын олборлож буй 12,000 тн жоншийг 75-ын агууламжтай хайлуур жоншны экспортын үнээр буюу 196.88 ам.доллаар тооцож үзвэл жилдээ 2.3 сая ам.долларын экспортын орлогыг Монгол улсад оруулж байгаа юм.

Орон нутагт оруулсан хувь нэмэр

ХАОАТ

Өлзийт хишиг буян ТББ-ын гишүүд 2014-2015 онуудад 20.6 сая төгрөгийн ХАОАТ төлсөн байна. Үүнийг Өлзийт сумын ОНХС-д 2015 онд батлагдсан 286.4 сая төгрөгийн төсөвтэй харьцуулбал 7.0 хувьтай нь тэнцэх дүн юм.

НД-ын шимтгэл

НД-ын шимтгэлд Өлзийт хишиг буян ТББ-ын гишүүд 2014-2015 онд нийтдээ 11.2 сая төгрөг төлжээ. Энэ нь 116 хүнд нэг удаа хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж олгоход хүрэлцэхүйц мөнгө юм.

Хандив тусламж

Сум, орон нутгийнхаа хөгжил дэвшилд зориулан Өлзийт хишиг буян ТББ-ын гишүүд 2013-2015 онд нийт 24.3 сая төгрөгийн хандив, тусламж өгсөн байна. Тухайлбал,

- Сумын баяр наадмыг зохион байгуулахад - 16.3 сая төгрөг
- Соёлын төвийн үйл ажиллагаанд дэмжлэг болгож 2.0 сая төгрөг

- Урлаг, соёлын төрөл бүрийн арга хэмжээнд 3.2 сая төгрөг
- Спортын арга хэмжээнд 2.8 сая төгрөг тус тус хандивласан байна.

Өлзийтхишиг буян ТББ-ын гишүүд, нөхөрлөлүүдээс спортыг хөгжүүлэх, тамирчдыг дэмжихэд анхаарал тавьж, багагүй хандив, тусламж өгдгийг онцлох нь зүйтэй. Тэдний дэмжлэг тусламжийн оролцоотойгоор Бэх-Очирын Өлзийбаатар мутай боксын Дэлхийн аваргын алтан медаль, Чинзүрхийн Энхбаатар самбо бөхийн Дэлхийн аваргын хүрэл медаль, Очирсүхийн Ууганбаяр жудо бөхийн Олон улсын тэмцээний хүрэл медаль авсан бөгөөд эдгээр тамирчдын энэхүү амжилтанд Өлзийт хишиг буян ТББ-ынхан тус нэмрээ оруулсан гэж хэлж болно.

Нийгэмд тустай үйлс

ТББ-ын бичил уурхайчид сумын төвийнхөө нутаг дэвсгэрт улиралд нэг удаа их цэвэрлэгээ хийдгээс гадна аймгийнхаа бусад сумдын тохижилтын зэрэг ажлуудад тогтмол хүн хүчээр тусалж ажилладаг байна.

Ирээдүйн төлөвлөгөө

Өлзийт хишиг буян ТББ-ын бичил уурхайчид өнөөдрийн байдлаар Шарангад хэмээх газарт ажиллаж байна. Тус олборлолтын газрын нөөц дуусахаар боломжтой газруудад орон нутагтайгаа хоёрлосон гэрээ байгуулан ажиллана.

Цаашид бичил уурхайчдын хамтарсан компани байгуулж, СХС-аас нэмж хөрөнгө оруулалт татан импортыг орлох, экспортонд бүтээгдхүүн гаргах боломжтой үйлдвэр байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үүнийхээ хүрээнд нэн түрүүнд ноос угаах үйлдвэрийн судалгаа, төсөл, төлөвлөгөө хийж эхлээд байна.

ТББ-ын танилцуулга

Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт жоншны илэрц гарч, сумын ажилгүй иргэд 2010 оноос эхлэн Засгийн газрын 308 дугаар тогтоолын дагуу нөхөрлөлийн хэлбэрээр нутгийн

захиргаатай гэрээ байгуулан жонш олборлож эхэлжээ.

Өлзийт хишиг буян ТББ 2013 оны дөрөвдүгээр сард 10 гишүүнтэйгээр үүсгэн байгуулагдаж байсан бол одоо нийт долоон нөхөрлөлийн 120 гишүүнтэй болж өргөжин, үйл ажиллагаагаа явуулж байна. Гишүүдийнх нь 50 нь эмэгтэй, 70 нь эрэгтэй хүн байна.

Өлзийт сумын ажилгүй бүх л иргэд ТББ-ын аль нэг нөхөрлөлд бүртгэлтэй байдаг бөгөөд ирэн, очин ажилладаг хүмүүсийг нэмж тооцвол маш олон хүн бичил уурхайн ажилд оролцдог. Тогтмол ажилласаар яваа 120 хүн байна.

Өлзийт хишиг буян ТББ-ын гишүүд жоншны олборлолт хийхээс гадна урьд өмнө нь сүйтгэгдэж орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийж ажилладаг. Азийн сангийн БОХТОН-II төсөлд хамрагдан 39.0 сая төгрөгийн нийт өртгөөр 10 га газарт нөхөн сэргээлт хийж, энэ ажилд давхардсан тоогоор 45 гишүүнээ ажиллуулсан байна.

Одоо олборлолт явуулж байгаа Шарангадын талбайд Өлзийт хишиг буян ТББ-ынхан 2014 онд сумын захиргаатай хоёр талт гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн юм. Түүнээс өмнө Ембүү-1, Ембүү-2 гэх газруудад мөн нутгийн удирдлагатай хоёрлосон гэрээ байгуулан ажиллаж байсан бөгөөд гэрээний дагуу нөхөн сэргээлт хийж хүлээлгэж өгчээ. Тэдгээр олборлолтын талбайнуудад нэг жил болон гурван сарын хугацаатай ажиллаж байсан бол Шарангадад нэг жил гаруй хугацаанд ажиллаж байна.

Сум, орон нутагтай байгуулсан гэрээний дагуу дотоод журмаа чанд сахиж ажлын байран дээр архи дарс уух, нийгмийн хэв журам зөрчих зэргээр хариуцлага алдсан бичил уурхайчныг цаашид олборлолтын талбайд ажиллуулахгүй байх зарчим баримталдаг ажээ..

2012-2016 онд ажилласан сумын Засаг дарга нь Өлзийт хишиг буян ТББ-ын тэргүүн, нөхөрлөлийн ахлагчаар ажиллаж байсан хүн учраас бичил уурхайчдыг ойлгож, дэмжиж ирсэн юм.

УЗ-ийн бүрэлдэхүүн

1. Г. Амартүвшин
2. Ц.Бат-Очир
3. Ц.Ганхуяг
4. А.Майнцэнгэл
5. О.Тэгшбаяр
6. Б.Үүрийнцолмон
7. Ц.Хатанбаатар
8. Б.Эрхэмбаатар

ХЗ-ийн бүрэлдэхүүн

1. Б.Батбаатар
2. Н.Болорчулуун
3. Б.Эрдэнэчулуун

Тэргүүн: О.Тэгшбаяр

Гүйцэтгэх захирал: Ц. Бат Очир

ТАХИЛГАТ ЛУСЫН БУЛАГ ТББ

Дундговь аймгийн Хулд сумын Тахилгат лусын булаг ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2011-2015 онуудад сум орон нутагтаа татвар, НД, хандив тусламж хэлбэрээр 965.5 сая төгрөгийн хувь нэмэр оруулаад байна.

Жилдээ Тахилгат лусын булаг ТББ-ын гишүүд 48,000 тонн жонш олборлож худалдааны компанид борлуулдаг бөгөөд үүнийг 85-ын агууламжтай хайлуур жоншны экспортын үнээр буюу 255.0 ам.доллараар тооцож үзвэл жилдээ 12.2 сая ам.долларын экспортын орлогыг Монгол улсад оруулж байгаа юм.

Бичил уурхайчид нэг тонн жоншийг газар дээр нь хамгийн багадаа 60.0 мянган төгрөгөөр борлуулдаг. Үүнийг жилийн нийт олборлолт буюу 48,000 тонн жоншоор тооцож үзвэл Хулд сумын иргэд жилд 2.8 тэрбум төгрөгийн орлого олж байгаа юм. Энэ мөнгө зөвхөн Хулд сум төдийгүй, Дундговь аймаг, Улаанбаатар хот, Монгол улс даяар эдийн засгийн эргэлтэд орж байгаа нь дамжиггүй юм.

Бизнесийн бусад үйл ажиллагаа


Тахилгат лусын булаг ТББ-ын гишүүн нөхөрлөлүүд жижиг, дунд бизнест хөрөнгө оруулан, сум орон нутагтаа үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн заримаас дурдъя.

- “Арвин булаг” нөхөрлөлийн зарим гишүүд блокны үйлдвэрлэл явуулж, зарим нь үхрийн аж ахуй эрхэлж байна.
- “Арвижих” нөхөрлөлийн зарим гишүүд хүнсний дэлгүүр ажиллуулж байна.
- “Цагаан хайрхан” нөхөрлөлийн зарим гишүүд оёдлын цех ажиллуулж байна.
- “Баянхангай” нөхөрлөлийн зарим гишүүд зочид буудал ажиллуулж, зарим нь 1000 мал худалдан аваад, мал аж ахуйн бизнес эрхэлж эхлээд байна.


Орон нутагт оруулсан хувь нэмэр

ХАОАТ

2011-2015 онуудад Тахилгат лусын булаг ТББ-ын гишүүн бичил уурхайчид сумын төсөвт нийт 371.6 сая төгрөгийн татвар төлснийг зургаар үзүүллээ.




Тэдний төлсөн татварыг жишвэл, Хулд сумын ЕБС-ийн 2015 оны жилийн төсвийн 96 хувьтай тэнцэх дүн юм.



НД-ын шимтгэл

Сумын захиргаатай байгуулсан гэрээний дагуу Тахилгат лусын булаг ТББ-ын гишүүд 2011-2015 оны зургадугаар сар хүртэлх хугацаанд нийт 233.9 сая төгрөгийн НД шимтгэл төлөөд байна. Үүнийг хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээгээр тооцож жишвэл 99 ахмад настанд бүтэн жил тэтгэврийг нь өгөхөд хүрэлцэх мөнгө юм.



Эрүүл мэндийн даатгал

Түүнчлэн тус ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2011-2015 онд нийт 2.26 сая төгрөгийг ЭМД-ын санд төвлөрүүлсэн байна.

Хандив тусламж

Тахилгат лусын булаг ТББ-ын гишүүд Нөхөн сэргээлтийн хуримтлалын санд 80 гаруй сая төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнийг БОХТОН-II төслийн баримталж буй нэгж га талбайг нөхөн сэргээхэд 5.0 сая төгрөг зарцуулах жишиг тооцоогоор бодвол 16 га газрыг нөхөн сэргээхэд хүрэлцэнэ.

Сум, орон нутгийнхаа хөгжил дэвшилд зориулан Тахилгат лусын булаг ТББ-ын бичил уурхайчид хандив тусламж үзүүлсээр ирсэн. 2011-2015 онд нийт 90.0 сая гаруй төгрөгийн хандив тусламж үзүүлсэн нь Хулд сумын эмнэлгийн 2015 оны төсвийн 43%-тай дүйцэх тооцоо гарч байна.

Нийгэмд тустай үйлс

Тахилгат лусын булаг ТББ-ынхан сумынхаа нутаг дэвсгэрт нийт 2,000 ширхэг мод тарьж, дүйцүүлэх биологийн нөхөн сэргээлт хийжээ. Нас гүйцсэн хоёр мод дөрвөн ам бүлтэй айлын бүтэн жилийн хүчилтөрөгчийг үйлдвэрлэдэг гэвэл тус ТББ-ын тарьсан 2,000 мод насанд хүрэх үедээ дөрвөн ам бүлтэй 1,000 өрхийн бүтэн жилийн хүчил төрөгчийг үйлдвэрлэнэ гэсэн үг. Дундговь аймгийн Хулд сум 657 өрхтэй, Дундговь аймаг 13,448 өрхтэй гээд уялдуулж бодвол үүнийг аймаг орон нутагтаа хийсэн томоохон хөрөнгө оруулалт гэж тооцож болно.

Мөн тус ТББ-аас 2015 оны зун сумын төвдөө цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж байгуулж өгчээ.

Ирээдүйн төлөвлөгөө

Нутгийн захиргаатай гэрээ байгуулан ашиглаж байсан Цагаан овоогийн олборлолтын талбайтай холбоотой асуудал гарсны улмаас Тахилгат лусын булаг ТББ-ын жонш олборлолт одоогоор түр зогсоод байна. Уг асуудлыг шийдэж олборлолтоо эхлүүлэхээр хөөцөлдөж байна.

Цаашид ТББ жоншны олборлолтыг тогтворжуулахад анхаарахын зэрэгцээ гишүүд, нөхөрлөлүүдээ бизнес эрхлэхэд дэмжиж ажиллах төлөвлөгөөтэй байгаа юм. Түүнчлэн ТББ-аа өргөжүүлэн орон нутгийн засаг захиргаа, иргэдийн хамтын эзэмшилтэй уул уурхайн компани болгохоор төлөвлөж байна.

ТББ-ын танилцуулга

Дундговь аймгийн Хулд суманд жоншны бичил уурхай эрхлэгч иргэдийн санаачилгаар 2010 оны 11 дүгээр сард Тахилгат лусын булаг ТББ байгуулагджээ. Одоогийн байдлаар 13 нөхөрлөлийн 188 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

УЗ нь тав, ХЗ нь гурван гишүүнтэй. ТББ-ын тэргүүнээр Ж. Рэнцэнпүрэв сонгогдон ажиллаж байна.

Засгийн газраас 2010 оны 12 дугаар сард батлан гаргасан 308 дугаар тогтоолын дагуу Хулд сумын ИТХ-аас 50.0 га талбайг Орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тогтоол гаргаж, АМГ-ын 2011 оны дүгнэлтийн дагуу Түймэрт цагаан хэмээх газарт нутгийн иргэд жоншны олборлолт хийж эхэлжээ.

ГУРВАН БУХТЫН ТОЛГОД ТББ

Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх багийн Гурван бухтын толгод ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2010-2015 онуудад сум орон нутагтаа татвар, патентын төлбөр, НД, хандив тусламж хэлбэрээр нийт 117.5 сая төгрөгийн хувь нэмэр оруулсан байна.

Бизнесийн бусад үйл ажиллагаа

ТББ-ын “Хишиг” нөхөрлөлийн ахлагч Д.Банзрагч 2012-2014 онуудад жонш олборлосон ашгаараа “Оргил” зоогийн газрыг барьж байгуулан, ажиллаж байна.

Мөн “Баялаг толгой” нөхөрлөлийн гишүүн Г.Баттулга нь мал худалдан авч, мал аж ахуй эрхэлж байна.

Орон нутагт оруулсан хувь нэмэр

ХАОАТ

Хэнтий аймгийн ИТХ 2015 оны төсвийн тодотголоороо сум, тосгоны Засаг даргын нөөц санд 110.0 сая төгрөг хуваарилсан байна. Тэгвэл Гурван бухтын толгод ТББ-ын гишүүдийн 2010-2015 онд ХАОАТ-т 22.9 сая төгрөг төлсөн нь Хэнтий аймгийн аль нэг сумын Засаг даргын нөөц сангийн 20 хувьтай тэнцэж байна.

Дээрх татвар болон Гурван бухтын толгод ТББ-ын гишүүдийн төлсөн ашигт малтмал олборлосны патентын төлбөрийн нийлбэр нь 60.4 сая төгрөг болж байгааг хүснэгтээр үзүүлээ.

Мянган төгрөгөөр

№	2010	2011	2012	2013	2014	2015	Нийт
1	1,627	2,552	1,864	5,880	9,375	1,700	22,998
2	1,352	5,622	5,782	9,380	14,035	1,200	37,370
Нийт							60,368

НД-ЫН ШИМТГЭЛ

Гурван бухтын толгод ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2010-2015 оны хооронд 23.4 сая төгрөгийг НД-ын санд төвлөрүүлсэн байна. Энэ нь НД-ын сангаас олгодог асаргааны тэтгэмжийг нэг хүн 403 сар олгож хүрэлцэхүйц дүн юм.

НД-ын шимтгэл, мянган төгрөгөөр

2010	2011	2012	2013	2014	2015	Нийт
745	1,544	2,387	5,434	8,716	4,596	23,422

Хандив тусламж

Байгуулагдсан цагаасаа хойш Гурван бухтын толгод ТББ-ын 11 нөхөрлөл, гишүүд нийт 33.8 сая төгрөгийн хандив, тусламжийг Засаг даргын ажлын алба, ЕБС, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, Батноров сумын хийд зэрэг байгууллагуудад өгсөн байна. Хэнтий аймгийн ИТХ-ын төсвийн тодотголын тухай мэдээнд дурдагдсанаар Батширээт сумын Хурхын голын гүүр барих ажил 35.0 сая төгрөгийн өртөгтэй байна. Өөрөөр хэлбэл, гүүр барих хэмжээний мөнгийг хандив тусламж болгон орон нутгийнхаа хөгжил дэвшилд зориулсан байна гэсэн үг.

Нийгэмд тустай үйлс:

Гурван бухтын толгод ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2013 онд 2,015 тн, 2014 онд 1,064 тн, 2015 онд 640 тн, гурван жилийн хугацаанд нийт 3,719 тн жонш олборлосон. Энэ нь сум, орон нутаг, улс орны эдийн засагт 621 сая төгрөгийн худалдан авалт, хуримтлал хийсэн гэсэн үг төдийгүй бүтээгдэхүүн нь шууд экспортонд гардаг учраас 952.3 сая ам.доллаароор Монгол улсын валютын нөөцийг нэмэгдүүлжээ.

Он	Нэг жилд Бичил уурхайчдын олборлосон жонш тн	Бичил уурхайчдын орон нутагтаа жонш борлуулдаг ханш төг	Бичил уурхайчдын орлого буюу сум, аймаг, улсын эдийн засагт оруулсан хувь нэмэр, худалдан авалт, төгрөг	Нэг тн жоншны экспортын үнэ 2015 оны 12 сарын байдлаар, доллар	Экспортын орлого буюу улсын валютын нөөцийг нэмэгдүүлсэн дүн
2013	2,015	150,000	302,250,000	256.08	516,001.20
2014	1,064	180,000	191,520,000	256.08	272,469.12
2015	640	200,000	128,000,000	256.08	163,891.20
Нийт	3,719		621,770,000		952,362

Ирээдүйн төлөвлөгөө

Оны төгсгөл дээр ТББ-ын бүх гишүүдийн ээлжит хурлаа хийж, УЗ-өө шинэчлэн шинэ бүтэц бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж эхлэхээр Гурван бухтын толгод ТББ-ынхан төлөвлөж байна. Мөн өмнөх жилүүдийн адил Бэрх сумын нийгмийн амьдралд идэвхтэй оролцож, боломжийн хэрээр хандив тусламж үзүүлж ажиллахын зэрэгцээ гишүүдээ сургаж хөгжүүлэх, бизнес эрхлүүлэх, нийгмийн асуудлуудыг нь сум орон нутагтайгаа хамтран шийдвэрлэх чиглэлээр ажиллана.

ТББ-ын танилцуулга

Хэнтий аймгийн Бэрх багийн ард иргэд 2007 оноос хувиараа жонш олборлож эхэлжээ. Гурван бухтын толгод ТББ

нь 2014 оны наймдугаар сард гишүүддээ үйлчлэх, байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах зорилготойгоор байгуулагдсан юм. Одоогийн байдлаар ТББ 12 нөхөрлөлийн 50 гаруй бичил уурхайчдыг эгнээндээ нэгтгэн, нутгийн захиргаатайгаа хоёр талт гэрээ байгуулан, жоншны олборлолт хийж байна.

Тус ТББ сум, орон нутгийнхаа бүхий л албаны болон олон нийтийг хамарсан ажлуудад баг, сумын бусад байгууллагуудын нэгэн адил идэвхтэй оролцдог.

Сумын нийт байгууллагуудын дунд уламжлал болон зохион байгуулагддаг урлаг, спортын наадамд жил бүр амжилттай оролцож ирсэн. Энэ нь сум орон нутагтайгаа ойлголцож, асуудал бэрхшээлээ шийдвэрлэхэд сайн нөлөөтэй байдаг учраас бусад бичил уурхайн ТББ-ууд ч энэ жишгийг сум орон нутагтаа нэвтрүүлбэл бичил уурхайн салбарыг нийгэмд хүлээн зөвшөөрүүлэхэд сайнаар нөлөөлөх юм.

УЗ-ийн бүрэлдэхүүн

1. К.Есенбол
2. н.Отгонбат
3. З. Хадбаатар
4. Л.Хатанбаатар
5. Б.Хандсүрэн
6. Д. Цэндсүрэн
7. Т. Энхболд

ХЗ-ийн бүрэлдэхүүн

1. Д.Алтансүх
2. С.Алтансүх
3. Д.Ганцэцэг
4. н.Камаш
5. Ш.Энхтүвшин

Тэргүүн: Д. Цэндсүрэн

Гүйцэтгэх захирал: К.Есенбол

ХУВИАРАА АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОГЧДЫГ ДЭМЖИХ ХОЛБОО ТББ

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ХАМОДХ ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2013-2015 онуудад сум орон нутагтаа татвар, НД, хандив тусламж хэлбэрээр нийт 168.9 сая төгрөгийн хувь нэмэр оруулжээ.

Шударга олборлолтын олон улсын стандартыг нэвтрүүлээ

ХАМОДХ ТББ-ынхан Шударга олборлолтын олон улсын стандарт шаардлагуудыг биелүүлж олборлосон алтаа олон улсын зах зээл дээр өндөр үнээр борлуулах эрхтэй болжээ. Энэхүү стандарт нь байгаль орчин, хүний эрх, жендерийн ямар нэгэн зөрчилгүй бичил уурхайн үйл ажиллагааны үр дүнд бий болсон алтыг дэлхийн зах зээлийн ханшаар авах төдийгүй, тэрхүү алтыг олборлодог бичил уурхайн байгууллагыг дэмжих зорилготой нэмэлт урамшууллыг авах боломжийг ч олгодог юм.

Шударга олборлолтын олон улсын стандартын шалгуурыг хангасан гэдгээ нотолж, үнэлгээ авахын тулд тус ХАМОДХ ТББ дунд шатны аудитаар гурван удаа орсон байна. Анхан шатны аудитаар тааруу үнэлгээ авч байсан боловч үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, дүрэм журмаа сайжруулж, засаж залруулсны үр дүнд 2014 оны есдүгээр сард 286 үзүүлэлт бүхий Шударга олборлолтын олон улсын стандартын шаардлагуудыг хангасныг Шударга олборлолтын Олон улсын аудитаар баталгаажуулснаар ХАМОДХ ТББ Шударга олборлолтын олон улсын системд нэгдэн орж гэрчилгээ авсан нь дэлхийд дөрөв дэх, Азидаа анхны тохиолдол болж байгаа юм. Энэ нь Монголын бичил уурхайн хөгжлийг дэлхийд харуулж, 2015 онд Монголын туршлагыг судлахаар хөгжиж буй зарим орны төлөөлөгчид хоёр удаа зочилсон байна.

Бизнесийн бусад үйл ажиллагаа

ХАМОДХ ТББ-ын “Хонгор хайрхан” нөхөрлөлийн зарим гишүүд зочид буудал, рестораны бизнес эрхэлж байна.

Мөн “Ундарга” нөхөрлөлийн зарим гишүүд цахилгаан барааны дэлгүүр ажиллуулж байна.

Орон нутагт оруулсан хувь нэмэр

ХАОАТ

ХАМОДХ ТББ-ын гишүүн бичил уурхайчдын нөхөрлөлүүд нь сум орон нутагтайгаа байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасны дагуу сар бүр 250.0 мянган төгрөгийн татвар төлдөг. Энэ нь Баян-Овоо сумын татварын орлогын 50 орчим хувийг бүрдүүлж байна.

№	Он	Төлсөн татвар/сая төг/
1	2013	52.6
2	2014	60
3	2015 он 9 сарын байдлаар	16
	Нийт	128.6

НД-ын шимтгэл

ХАМОДХ ТББ-ын гишүүн 48 бичил уурхайчин 2014 онд 1.7 сая төгрөгийн НД-ын шимтгэл төлсөн байна.

ЭМД-ын шимтгэл

Мөн 2014 онд ХАМОДХ ТББ-ын гишүүн 72 бичил уурхайчин 933.9 мянган төгрөгийн ЭМД-ын шимтгэл төлсөн байна.

Хандив тусламж

ХАМОДХ ТББ нь гишүүн бичил уурхайчид сум, орон нутагтаа нийт 37.7 сая төгрөгийн хандив тусламж өгсөн байна. Үүнийг Баян-Овоо сумын наадмын төсөв 2015 онд 5.0 сая төгрөг байсантай жишиж тооцвол тус сумын наадмыг 7 удаа тэмдэглэж хүрэхээр хөрөнгө юм.

- Засаг даргын Тамгын газрын дотор заслыг хийж гүйцэтгэхэд 14.0 сая төгрөг,
- Баян-Овоо сумын ЗДТГ-ын албан хаагчдын ширээ сандал, тоног төхөөрөмж шинэчлэхэд 2.7 сая төгрөг,

- Малчдын өвөлжөөг засварлан тохижуулахад 7.0 сая төгрөг,
- Баян-Овоо сумын багийн эмч, байгаль хамгаалагч нарыг унаажуулахад таван мотоцикл,
- Уран хайрхан хоёр дугаар багийн төвийн тохижилтод 3.0 сая төгрөг,
- Хоёр өрхийг малжуулахад 4.0 сая төгрөг,
- Өрх толгойлсон нэг эмэгтэйд гэр авч өгөхөд 2.0 сая төгрөг гэх мэтчилэн бодит тусламж үзүүлсэн байна.


Нөхөн сэргээлт

Тус ТББ нь жил бүр нөхөн сэргээлт хийдэг бөгөөд 2013 онд 4.0 га, 2014 онд 4.2 га талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгчээ.

Нийгэмд тустай үйлс

Бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг баяжуулдаг хүдэр боловсруулах цехийн технологийн үлдэгдлээс гарсан шламийг зарж борлуулсны орлогоос Баянхонгор аймаг 1.7 тэрбум, Баян-Овоо сум 140 сая төгрөгийг бүтээн байгуулалтад зарцуулсан байна.

Баянхонгор аймагт хуваарилагдсан 1.7 тэрбум төгрөг нь 2015 оны Баянхонгор аймгийн бүх сумдын ОНХС-ийн хөрөнгийн нийлбэр болох 5.9 тэрбум төгрөгийн 29%-тай тэнцэж байна.



Мөн ТББ-ын бичил уурхайчид олборлолт хийж буй тухайн суурьшлын бүсийнхээ ойролцоох малчин айл өрхүүдээс мах, сүү, цагаан идээ болон малын гаралтай түүхийн эдийг худалдан авч, тэдгээр айл өрхүүдийн орлогыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлдэг.

Сум, орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан мод тарих, хог хаягдал цэвэрлэх, байгаль хамгаалах ажилд ХАМОДХ ТББ гишүүн бичил уурхайчдынхаа хүчийг дайчлан, идэвхтэй оролцож иржээ.

Ирээдүйн төлөвлөгөө

Шударга олборлолтын олон улсын стандартын хоёрдугаар шатны шалгуурт нийцүүлэн ТББ-ынхаа бүтэц, зохион байгуулалт, дүрэм журмыг сайжруулахаар ажиллаж байна.

Тэсэлгээний агуулахыг бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Олборлолтын талбайгаа нэмэгдүүлэх талаар Спейшл майнз ХХК-тай яриа хэлэлцээ хийж, үр дүн гаргах ойрын зорилттой аж.

Байгаль орчныг хамгаалах чиглэлийн үйл ажиллагаагаа идэвхжүүлэхэд анхаарлаа хандуулж ажиллана.

Бичил уурхайчдын ХЗХ байгуулж аймаг, сумынхаа хэмжээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг болохыг зорьж байна.

ТББ-ын танилцуулга

ХАМОДХ ТББ долоон жилийн тэртээ буюу 2009 онд байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, бичил уурхайг дэмжих зорилготойгоор Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Цагаан цахирын үндсэн ордод ажилладаг иргэдийг зохион байгуулалтад оруулж, есөн нөхөрлөлийн 72 гишүүнтэйгээр анх байгуулагдаж байв.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу зохион байгуулалтад орсон иргэдэд ажиллах газар буюу ажлын байр нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компанийн лицензтэй талбай байсан учир гар аргаар ашиглах боломжтой, үйлдвэрийн аргаар ашиглаж дууссан газрыг нь авч ажиллахын төлөө ТББ-ын

нийт гишүүд, орон нутгийн иргэд, тухайн үеийн орон нутгийн удирдлагууд хамтран багагүй хугацаанд хөөцөлдсөн байна.

Энэ хугацаанд тус уурхайн компанитай хамтарч ажиллах саналыг олон удаа тавьж, олон удаа татгалзсан хариу авч байсан боловч гишүүдээ тогтвортой ажлын байртай, хуулийн дагуу ажиллуулахын төлөө тууштай явж олон удаагийн уулзалт, жагсаал цуглаан хүртэл зохион байгуулж гурван жил явсны эцэст 2010 оны Засгийн газрын 308 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Спейшл майнз ХХК-тай 2012 онд 30 га газарт гурвалсан гэрээ байгуулан өнөөг хүртэл хамтран ажиллаж байна.

УЗ-ийн бүрэлдэхүүн

1. Ц. Бат-Эрдэнэ
2. Ж. Баянмөнх
3. М.Болормаа
4. Д. Долгорсүрэн
5. Л. Жанчивдорж
6. М. Мөнхбаяр
7. М. Цэцгээ
8. Г. Чимэдцэрэн

ХЗ-ийн бүрэлдэхүүн

1. Г. Ариунжаргал
2. Н. Баасанбат
3. Э. Намхайнямбуу

Тэргүүн: Ч. Отгонбаатар

Нягтлан бодогч: Дэлгэрдалай

Нарийн бичиг: Б. Батбаатар

Таван хүний бүрэлдэхүүн бүхий авран туслах багтай.

БАЯНГОЛ БАЯСГАЛАНТ ХАЙРХАН ТББ

Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн 15 хувиараа ашигт малтмал олборлогч иргэн 2013 оны дөрөвдүгээр сарын 16-нд Баянгол баясгалант хайрхан ТББ-ыг байгуулсан юм.

Тус ТББ-ын гишүүн бичил уурхайчдаа сум, орон нутгийн олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцуулж, өөрсдийг нь мэргэжлийн боловсролын сургалтад хамруулах, олсон орлогоосоо тодорхой хэмжээний хандив, тусламж үзүүлэх зэргээр орон нутагтаа хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Ажилсаг арван хуруу төсөл буюу ажлын цагаан бээлийний цех

Баянгол баясгалант хайрхан ТББ-ын бичил уурхайчид ШХА-ийн ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр 2015 оноос “Ажилсаг арван хуруу” төслийг сумандаа амжилттай хэрэгжүүлж байна. ТБУТ-ийн санхүүжилтээр ажлын цагаан бээлий нэхэх машин авч, өөрсдөө ажлын байр, түүхий эдийн зардлаа шийдсэнээр ажлын бээлийний жижиг үйлдвэртэй болжээ.

Тэд үйлдвэрлэсэн ажлын бээлийгээ Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн дэлгүүрүүдэд бөөний үнээр борлуулж, уул уурхайн компаниудад нийлүүлж байна. Хайлааст баг нь бичил уурхайчид төдийгүй уул уурхайн олон компаниуд үйл ажиллагаа явуулдаг төвлөрсөн газар учраас төрөл бүрийн бараа бүтээгдэхүүн, тэр тусмаа ажлын бээлийний эрэлт хэрэгцээ их байдаг. Тодруулбал, тус баг, суманд 20 гаруй уул уурхайн компани, 5000 гаруй бичил уурхайчид ажиллаж амьдардаг.

“Ажилсаг арван хуруу” цех нэг цагаан бээлийг 200 төгрөгийн өртгөөр үйлдвэрлэж, бөөний үнээр 350 төгрөгөөр борлуулж байна. Цагаан бээлий оёдог машин ямар нэг сааталгүй ажиллавал өдөрт 200 ширхэг бээлий үйлдвэрлэх хүчин чадалтай, машиныг нэг хүн тогтмол хянаж ажиллах шаардлагатай байдаг. Тиймээс Баянгол баясгалант хайрхан

ТББ-ын дөрвөн гишүүн ээлжлэн цаг заваа зохицуулан ажиллаж байна.

Төсөл хэрэгжсэнээр дөрвөн бичил уурхайчин тус бүр бусад ажил төрөлдөө саад бололгүйгээр жижиг үйлдвэр эрхэлж, бичил уурхайн бус аргаар сар бүр 200,000 төгрөгийн нэмэлт орлого олох боломжтой болсон ба анхны хөрөнгө оруулалтаа зургаан сарын хугацаанд нөхөж чаджээ.

Орон нутагт оруулсан хувь нэмэр

Нийгэмд тустай үйлс

Баянгол баясгалант хайрхан ТББ-ын гишүүн бичил уурхайчид олсон орлогоосоо хичээлийн шинэ жилээр Заамар сумын “Шижир алт” дунд сургуулийн дөрвөн сурагч, бэлтгэл цэцэрлэгийн нэг хүүхдэд хичээлийн бүрэн хэрэгсэл, цүнхний хамт авч өгсөн.

Мөн “Шижир алт” дунд сургуулийн сургалт, эрүүл ахуйд зориулан чацарганын мод суулгаж өгсөн байна.

Ирээдүйн төлөвлөгөө

Баянгол баясгалант хайрхан ТББ-ын Н.Эрдэнэчимэг, Б.Нарангэрэл, Б.Түмэнжаргал, Б.Наранзул, Ц.Цэвэлмаа, Н.Отгонпүрэв, С.Болормаа, Х.Гэрэлцэцэг, Т.Ариунтуяа, Ц.Саран, Н.Наранцэцэг, Л.Ганжаргал, Б.Оюун-Эрдэнэ, Д.Одончимэг нарын 14 бичил уурхайчин 2015-оос эхлэн Заамар сумын МСҮТ-д оёдол, эсгүүрийн мэргэжлээр суралцаж байна. ТББ-аас тэдгээр гишүүдээ оёдлын бизнес эрхлэхэд нь дэмжиж ажиллахаар төлөвлөжээ.

ТББ-ын танилцуулга

2014-2015 онд “Тод ундарга” ХХК-тай хамтран 2.5 га газрыг Баянгол баясгалант хайрхан ТББ-ын гишүүд нөхөн сэргээсэн юм. 2016 онд уг газартаа “Төглийн хишиг” ТББ-тай хамтран биологийн нөхөн сэргээлт хийж, мод тарихаар төлөвлөж байна.

Цаашид нөхөн сэргээлт болон жижиг дунд бизнес эрхлэх чиглэлээр гишүүдээ дэмжиж ажиллах төлөвлөгөөтэй байгаа ба энэ ажлын хүрээнд ТББ-ын найман гишүүн 2013 онд Төв аймгийн Заамар сумын МСҮТ-д ойжуулалтын сургалтад хамрагдсанаас нэг хүн үргэлжлүүлэн жилийн сургалтад сууж мэргэжлийн үнэмлэхтэй төгссөн байна.

УЗ-ийн бүрэлдэхүүн

1. Ч.Баянзул
2. М.Мөнхнасан
3. Д.Наранзул

ХЗ-ийн бүрэлдэхүүн

1. Д.Болормаа
2. Л.Ганчимэг

Тэргүүн, гүйцэтгэх захирал: Н. Наранцэцэг

ЦАНЧИР БАЯНБУЛАГ ТББ

Баянхонгор аймгийн Өлзийт сумын Цанчир баянбулаг ТББ-ын гишүүн бичил уурхайчид эсгий эдлэл үйлдвэрлэх, зун нь ногоо тарих, сэргээн засах чиглэлийн эмнэлэг ажиллуулах зэргээр аймгийнхаа болон сумынхаа эдийн засаг, бизнесийн хөгжилд нэмэр тусаа оруулж байна.

Төмс, хүнсний ногоо тариалалт

Цанчир баянбулаг ТББ-ын гишүүн бичил уурхайчид өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор 2015 онд төмс тарьжээ. Өөрийн гэсэн ногооны талбайгүй учир 1.0 га ногооны талбайг дөрвөн сарын хугацаанд 250.0 мянган төгрөгөөр түрээслэн авч, дөрөвдүгээр сарын сүүл, тавдугаар сарын эхээр тариалалтаа хийж есдүгээр сард хурааж авсан байна.

Зундаа бичил уурхайчид олборлолтын ажлынхаа зав зайгаар ээлжлэн ногооны талбайдаа очиж ажиллан, зэрлэг зулгааж, усалж арчилж байжээ. Мөн нэг бичил уурхайчнаа талбайнхаа манаачаар томилж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулан, таван сар ажиллуулж 960.0 мянган төгрөгийн хөлс олгосон байна.

Эцэст нь нөхөрлөлийн гишүүд хамтын хөдөлмөрийн үр дүнд нийт 2.5 тн төмс хураан авч, 250 кг-ыг нь гишүүддээ тараан өгч, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцон 2,250 кг төмсийг нэг кг-ийг нь 900 төгрөгөөр борлуулан, 2,025,000 төгрөгийн орлого олсон байна.

Хавраас намар хүртэлх хугацаанд давхардсан тоогоор 15 бичил уурхайчин төмс тарих ажилд оролцжээ.

Эсгий эдлэлийн гар үйлдвэрлэл

Тус ТББ-ын гишүүн Түмэндэмбэрэл, Болорцэцэг, Өлзийзаяа, Буянтогтох, Пүрэвжагдаг, Төмөрчөдөр нарын зургаан эмэгтэй хонины ноосыг гар аргаар боловсруулан гэрийн эсгий тавчиг /том, жижиг/, домбо, сандлын дэвсгэр, Монгол гутлын оймс зэргийг хийж, орон нутгийн зах зээлд борлуулж байна.

Сэргээн засах чиглэлийн эмнэлэг

Эмч мэргэжилтэй, Цанчир баянбулаг ТББ-ын УЗ-ийн гишүүн Д.Дуламдорж, тэргүүн Ч.Төмөрчөдөрийн хамт 2015 оны есдүгээр сараас эмнэлэг байгуулан, үйл ажиллагаагаа явуулж байна.

18.0 сая төгрөгөөр хаш чулуун эмчилгээний Солонгос тоног төхөөрөмж худалдан авч, сарын 250.0 мянган төгрөгөөр байр түрээслэн, сэргээн засах чиглэлийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлж байна.

Бичил уурхайчдын эмнэлгийн доорх үйлчилгээг үзүүлж байна. Үүнд,

-Дулааны эмчилгээ	-Хөдөлгөөний дутагдал нөхөх
-Зүү төөнүүрийн эмчилгээ	-Хэт улаан туяаны эмчилгээ
-Цэгэн иллэгийн эмчилгээ	-Ионжсон усан эмчилгээ
-Хэвлийн бүсэн эмчилгээ	-Шарлагын эмчилгээ
-Соронзон орны эмчилгээ	-Нөхөн сэргээх эмчилгээ

Тус эмнэлэгт нэг хүн нэг өдөрт бүх аппаратаар эмчилгээ хийлгэх үнэ 4,000 төгрөг болох бөгөөд 10 хоногийн курс эмчилгээ 40,000 төгрөгийн үнэтэй байна.

Д.Дуламдорж, Ч.Төмөрчөдөр нар аймгийнхаа бичил уурхайчдад 50% хөнгөлөлттэй үйлчилдэг байна. 2015 оны аравдугаар сард хөдөө сумдаар тойрон явж, явуулын эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үүнд 40 гаруй хүн хамрагдсан байна.

Орон нутаг болон ТБУТ-өөс авсан дэмжлэг

Цанчир баянбулаг ТББ төмсний тариалалтдаа ШХА-ийн ТБУТ-өөс 3.0 сая төгрөгийн дэмжлэг авч ногооны талбайдаа хайс, хамгаалалт хийжээ.

Мөн өөрийн хөрөнгөөр ногооны талбайдаа усалгааны систем хийж, үрийн төмс, бусад шаардлагатай багаж тоног төхөөрөмжөө худалдан авсан байна.

Ирээдүйн төлөвлөгөө

Цанчир баянбулаг ТББ-ын гишүүд цаашид дараах чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд,

- Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн гараар сүйтгэгдсэн, хуучин олборлолт хийж байсан газруудад нөхөн сэргээлт хийхээр гэрээлэн авч ажиллах.
- Гишүүдээ хамруулсан ХЗХ байгуулах. Энэ чиглэлээрээ мэргэжлийн тусламж дэмжлэг авахаар ТБУТ-д хандаад байна.

ТББ-ын танилцуулга

2013 оны 11 дүгээр сарын 13-нд 20 бичил уурхайчин, хоёр нөхөрлөлтэйгөөр анх Цанчир баянбулаг ТББ-аа үүсгэн байгуулсан бөгөөд өнөөг хүртэл уг бүрэлдэхүүнээрээ үйл ажиллагаа явуулж байна.

УЗ-ийн гишүүд:

1. Б.Баясгалан
2. О.Болорцэцэг
3. М.Буянтогтох
4. Д.Дуламдорж
5. Э.Энхбаясгалан

ХЗ-ийн гишүүд:

1. Д.Баярсайхан
2. Э.Баярбаясгалан
3. Л.Лхагвасүрэн

Тэргүүн: Ч.Төмөрчөдөр

Гүйцэтгэх захирал: Д.Баярсайхан

ДУУШ МАНДАЛ ХАЙРХАН ХОЛБОО ТББ

Гишүүдийнхээ амьдралын баталгааг хангахын тулд нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх зорилготой бичил уурхайчдын Дууш мандал



хайрхан холбоо ТББ нь 2008 оноос одоог хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. Сэлэнгэ аймгийн Мандал сумын тус ТББ өнөөдрийн байдлаар 13 нөхөрлөлийн 130 гаруй гишүүнтэй.

Явган замын хавтан, блок үйлдвэрлэл

Дууш мандал хайрхан холбоо ТББ-ын “Хишиг” нөхөрлөлийн гишүүд бичил уурхайгаас олсон орлогоо хуримтлуулан 23.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, үйлдвэрийн байр, хашааны хөрөнгө оруулалт хийж, барилгын блок, явган замын хавтан, хашлага, авто замын бродюр үйлдвэрлэх бизнесээ эхлүүлжээ. Бүтээгдэхүүний онцлогоос шалтгаалаад захиалга орж ирсэн үед нь таван хүнийг түр ажлын байраар хангаж үйлдвэрлэлээ явуулж байна.

Үйлдвэрлэлийн явцад усны хэрэглээ их гардаг бөгөөд тэр бүхэнд алсаас ус зөөх нь үйлдвэрийн зардлыг өсгөж, технологийн горимын дагуу чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд саад болж байсан учраас өөрийн үйлдвэрийн хашаанд худагтай болох хэрэгцээ гарсан.

Хашаандаа гүний худагтай болсон “Хишиг” нөхөрлөлийн блок, хавтангийн үйлдвэрийн технологийн горим сайжирснаар чанартай бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх нөхцөл бүрдсэн төдийгүй тус сумын Баян суудал гуравдугаар багийн Гандан хэсгийн 120 гаруй өрх авто зам хөндлөн гарч холоос ус зөөдөг байсан хүндрэл бэрхшээлийг ч давхар шийдвэрлэжээ.

Үүгээр зогсохгүй өвөл, зунгүй амьдрах боломжтой дулаан худгийн байшинг өөрийн хөрөнгөөр 3.5 сая төгрөг зарцуулан барьж худгийн ус түгээгчээр нэг хүнийг байнгын ажлын байртай, орон гэртэй болгосон байна.

“Хишиг” нөхөрлөлийн гишүүн бичил уурхайчид ТБУТ-ийн санхүүжилтээр гүний худагтай болсноосоо хойш 2015 оны аравдугаар сар хүртэлх хугацаанд 7.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, түүнээс гурван сая төгрөгийн борлуулалт хийгээд байна.

Орон нутаг, ТБУТ-ийн дэмжлэг:

ТБУТ-ийн 5.6 сая төгрөгийн санхүүжилтээр гүний худаг ухах, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлжээ. Сумын захиргаанаас худаг ухах зөвшөөрлийг олгож дэмжлэг үзүүлсэн байна.

Орон нутагт оруулсан хувь нэмэр

2015 онд Дууш мандал хайрхан холбоо ТББ найман жилийн ойгоо тохиолдуулан сумынхаа ард иргэдэд туслах Сайн үйлсийн аяныг өрнүүлсэн юм.

Орлого багатай зарим өрхүүдийг ТББ-ын ажилдаа туслуулж, ажлын байраар хангахын зэрэгцээ гишүүдийнхээ хамтын хүч, хөдөлмөрөөр байшин барихад нь тусалсан байна. Тухайлбал, 2015 онд ТББ-ын гишүүн бичил уурхайчдын

дэмжлэгээр Түмэндэлгэрийн Заяабаатар дутуу барьсан байшингаа дуусгасан бол зургаан хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй Баярагийн Амарбаяр шинэ байшин барьж оржээ.

Дууш мандал хайрхан холбоо ТББ-ын гишүүд өвчин зовлонтой нэгнээ үргэлж тусалж дэмжиж явдаг бөгөөд хүнд өвчтэй С.Хишигтогтох, Б.Самбалхүндэв нарт тус бүр 250.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж өгчээ. Мөн сүүлийн хоёр жилийн турш өвчтэй байгаа Ч.Оюун-Эрдэнэд бусад бичил уурхайчид болон ТББ-ын зүгээс байнга дэмжиж тусалсаар байна.

Мөн 2015 онд хүүхэдтэй болсон гурван залуу гэр бүлд ТББ-аасаа хандив өгсөн байна.

Түүнчлэн Мандал сумын зургаан хүүхэдтэй, нөхөр нь өвчтэй, эхнэр нь ажилгүй, орон гэргүй байсан гэр бүлд 1.8 сая төгрөгөөр таван ханатай, хоёр давхар бүрээстэй гэр авч өгсөн байна.

2015 оны 11 дүгээр сард 2.0 сая төгрөг зарцуулан сумын ард иргэд болон гишүүн бичил уурхайчдаа хамруулан гар бөмбөг, одон бөмбөгийн тэмцээн, дууны тэмцээн зохион байгуулж, мөн сумынхаа шилдэг 10 залууд шинэ жилийн бэлэг өгчээ.

Ирээдүйн төлөвлөгөө

Цаашид орон нутагтаа ТББ-ынхаа нэр хүндийг сайжруулах, нийгмийн сайн сайханд хувь нэмэр оруулах үүднээс сайн үйлсийн аяныг тогтмол явуулж байхаар төлөвлөөд байна.

Мөн гишүүдээ бичил уурхайгаас олсон орлогоо зөв зохистой зарцуулах, өөр бизнест хөрөнгө оруулалт хийхэд нь дэмжих чиглэлээр анхаарч ажиллахаар зорьж байна.

Мандал суманд БНЧУ, ШХА-ийн санхүүжилтээр баригдаж, орон нутгийн өмчид шилжүүлсэн хүдэр баяжуулах цехийн үйл ажиллагааг хариуцаж ажиллуулдаг болохоор хөөцөлдөж байна.

ТББ-ын танилцуулга

Дууш мандал хайрхан холбоо ТББ 2012 оны тавдугаар сард Ноёд олборлолтын газрыг сум орон нутагтайгаа хоёрлосон гэрээ байгуулан, албан ёсоор авч одоог хүртэл тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

АМГ-ын захиргааны зөвлөлийн 2009 оны наймдугаар сарын наймны өдрийн хуралдаанаар Мандал суманд хүдэр баяжуулах цех байгуулах шийдвэр гарснаар мөнгөн усгүй технологиор алт баяжуулах боломжтой болж, бичил уурхайчдын ажлын нөхцөл сайжирсан юм.

Тус ТББ олборлолтын үйл ажиллагаандаа ХАБЭА-н дүрэм, журмуудыг даган мөрдөж ажилладаг ба 2010 онд уул уурхайн аврах албаны сургалтад таван бичил уурхайчнаа хамруулж дэргэдээ Авран туслах багтай болжээ.

Өнгөрсөн хугацаанд ТББ-ын гишүүдийг чадавхижуулах ажлыг эрчимтэй явуулж, ХАБЭА, нөхөн сэргээлтийн сургалтад давхардсан тоогоор 230 гаруй бичил уурхайчныг хамруулсан байна.

Азийн сангаас хэрэгжүүлж буй БОХТОН-II төслийн хүрээнд Мандал суманд бичил уурхай эрхлэгчдээр загвар нөхөн сэргээлтийг 2014 онд гүйцэтгүүлсэн юм. Уг ажлын хүрээнд Ноёд олборлолтын газарт 13.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1.3 га талбайд Дууш мандал хайрхан холбоо ТББ нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэн, Мандал суманд хүлээлгэн өгөөд байна.

ЭВСЭГ ТУУЛЫН ГҮҮР ТББ

2011 онд 50 бичил уурхайчинтайгаар байгуулагдсан Эвсэг туулын гүүр ТББ 2012 онд Заамар сумын Өл цагаан чулуут гэдэг газар гурван сарын турш 28 гишүүнтэйгээр ажиллажээ.

ТББ-ын хувьд санхүүгийн тайлангаа гаргаж өгөхгүй байсан тул 2015 оны 11 дүгээр сард УБЕГ-аас татан буулгаж, бүртгэлээс хассан байна.

ТББ-д харьяалагдаж байсан бичил уурхайчдын зарим нь Заамар суманд 2015 онд шинээр бичил уурхайн зөвшөөрөл гарсан газар дээр бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэрээр гэрээ байгуулан ажиллаж байгаа бол зарим нь өөр ажил хийж, зарим нь жижиг, дунд бизнес эрхэлж эхлээд байна.

Гахайн аж ахуй

“9 найзууд” хоршооны дарга: Н.Туул

Хоршооны нягтлан: З. Цэцэгсүрэн

ХЗ-ийн гишүүд: Мөнх-Эрдэнэ, Мөнхбаатар

“9 найзууд” хоршооны гишүүд: Бүгд Эвсэг туулын гүүр ТББ-ын гишүүн байсан.

Хоршооны гишүүдийн тав нь эмэгтэй, дөрөв нь эрэгтэй ажээ.

Бизнес эхлэхийн өмнөх нөхцөл

“9 найзууд” хоршооны гишүүд 2008 оноос хувиараа алт олборлож байгаа хэдий ч тэр бүр олборлолтын албан ёсны газар шийдүүлж чаддаггүй байсны улмаас үйл ажиллагаа нь тогтворжихгүй байв. Тиймээс өөр бусад төрөл бүрийн тогтмол бус ажил, мал аж ахуй эрхлэн өрхийн амьжиргаагаа залгуулцгааж байв. Бичил уурхайгаас болон бусад түр зуурын ажил, мал аж ахуйгаасаа тодорхой хэмжээний орлого олж байсан боловч одоог хүртэл амьдралд нь тодорхой ахиц өөрчлөлт гаралгүй, олсон орлогоо тухай бүрт нь зарцуулж дуусгаад, хуримтлалгүй үлддэг байжээ.

Бизнесийн түүх

Бичил уурхайчид ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр 2014 оноос эхлэн нөхөрлөлийн зохион байгуулалтад орсноор хамтран ажиллах, хамт олон болох, хоорондоо ойлголцох туршлага болж өгчээ.

Улмаар Эвсэг туулын гүүр ТББ-ын есөн залуу гишүүн санаа нэгдэж, бичил уурхайгаас олсон орлогоосоо хуримтлал үүсгэн, түүгээрээ “9 найзууд” хоршоог байгуулан, гахайн аж ахуй эрхлэхээр хөрөнгө оруулалт хийлээ.

Төсөл хэрэгжүүлэгч “9 найзууд” хоршоо 2015 оны дөрөвдүгээр сарын 20-ны өдөр байгуулагдсан юм. Гишүүн тус бүр 700.0 мянган төгрөг нийлүүлэн 6.3 сая төгрөгийн дундын сан үүсгэж үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.

Бичил уурхайчид олсон орлогоосоо бага гэлтгүй хуримтлал үүсгэн бизнес эхэлье гэвэл ганцаараа биш ТББ-ын бусад гишүүдтэйгээ хамтран бие биендээ дэм тус болж бизнес эрхэлбэл эрсдэл багатай, нэг хүнээс бага мөнгө гарсан хэдий ч нийт дүндээ боломжийн хөрөнгө босгон бизнестэй болох боломжтойг “9 найзууд” харуулж чадсан юм.

Хамтарч бизнес хийхийн давуу талуудыг тэд ингэж харж байна:

- Өөр бусад ажил төрлөө хэвийн үргэлжлүүлэхийн зэрэгцээ бага цаг зарцуулан шинэ нэмэлт орлого олох боломжтой бизнесийг эхлүүлж чадсан. Тухайлбал, олуулаа нийлж бизнес хийснээр шинээр эхэлж буй бизнестээ зарцуулах нэг хүний цаг зав ажлын ачаалал нь багасаж өөр бусад орлого олдог ажлаа цалгардуулахгүй байх боломжтой байсан.
- Нэг хүний үүрэх санхүүгийн эрсдэл, ачаалал бага байсан. Нэг хүн ганцаараа 6.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бол өрх гэрийн амьжиргааны зардлаасаа хүртэл танаж, хэцүүхэн байх байсан бол найман хүнтэй нэгдэж хөрөнгө оруулалт хийснээр нэг хүнээс ердөө 700.0 мянган төгрөг гарч, өрхийн амьжиргаандаа нөлөөлөхгүйгээр

өөрийн гэсэн бизнестэй болж чадаж байна.

- Олны хүч оломгүй далай буюу хөдөлмөрөөрөө хөрөнгө оруулалт хийх боломжтой болсон. Шинээр эхэлж буй аливаа ажил бизнест, олон цагийн хүч хөдөлмөр шаарддаг ба ганц хүн гахайн аж ахуй эрхэлж байсан бол тухай бүрд нь ажилчин хөлслөх буюу өөрөө ганцаараа ажиллалаа гэхэд олон өдөр хоногийг зарцуулж бусад ажил төрөлдөө саад болж шинээр эхэлж буй бизнесээсээ хэтэрхий хамааралтай болох байсан бол “9 найзууд” хоршооны залуус нэг хүн есөн өдөр хийх байсан ажлыг бүгдээрээ нэг л амралтын өдрөөрөө амжуулчихаад, бусад ажил төрлөө хэвийн үргэлжлүүлж байснаараа маш их давуу талтай байна.
- Далайд дусал нэмэр буюу шинэ эхэлж буй бизнест нэг шинэ айл шиг жижиг сажиг хүн анзаарахааргүй хэдий ч зайлшгүй хэрэгцээтэй олон зүйлс хэрэг болдог ба ганц хүнд тэр бүхэн нь байхгүй тул шинээр худалдаж авч бизнестээ зардал гарган, шинээр хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байдаг бол есөн хүн өөр өөрийн гэр орон, ах дүү, төрөл садангаас ашиглахгүй, хэрэглэхгүй байгаа хувин сав, хувцас хунараас авахуулаад наад захын хэрэгцээний зүйлсээ нийлүүлэхэд бизнестээ маш их хөрөнгө оруулалт хэмнэж чаддаг байна.

Анхны хамтын хөрөнгө оруулалтаа дараах байдлаар зарцуулан бизнесээ эхэлжээ.

№	Зардлын төрөл	төгрөг
1	Гахайн зуны байр	850,000
2	Гахайн тэжээлийн будаа	500,000
3	Ажилчдын гэр	1,200,000
4	тээврийн зардал болон бусад зардал	500,000
5	Гурван хээлтэй мэгж	2,700,000
6	Үлдэгдэл бэлэн мөнгө	550,000
	Есөн гишүүний 700,000 төгрөг, нийт 6.3 сая төгрөг	6,300,000

Бизнесээ эхэлснээс хойш зуны байр барих, гахайгаа хариулах, хооллох ажлыг хоршооны гишүүд ажлын хуваарь гарган, ээлжилж болон хамтран гүйцэтгэж байсан.

Бизнесийн өнөөгийн байдал:

Өмнө нь эзгүй газар байсан Туул голын нэгэн эрэг дээр одоо 150 тооны гахайн багтаамжтай, сар бүр 10 гахай зах зээлд нийлүүлж ажиллахад ашиглах боломжтой 6х8 харьцаатай гахайн өвлийн дулаан байр, түүнтэй залгаа зуны байр баригдсан байна.

Одоогоор гахайн өвлийн байрандаа цаашид тогтвортой өсгөж үржүүлэхэд зохистой бүтэц бүхий 12 гахай тэжээж байна. Тухайлбал,

- 2015 оны 11 дүгээр сард, зуны зургадугаар сард төрсөн 12 торойгоо нэг бүрийг нь 250,000 төгрөгөөр борлуулсан.
- Зуны зургадугаар сард төрсөн зургаан охин торой байгаа ба ирэх оны дөрөвдүгээр сард үржилд орох насанд хүрнэ.
- Нийт таван мэгж байгаа ба хоёр нь ирэх оны нэгдүгээр сарын сүүлээр, гурав нь ирэх оны гуравдугаар сард тус тус төллөнө.
- Нэг ландерс үүлдрийн бодон байна.

Сургамж:

Гахай худалдаж авахдаа үүлдэр угсааг нь мэргэжлийн хүмүүсээр сайн тодорхойлуулж авах, баталгаатай найдвартай газраас худалдаж авах ёстой юм байна гэдгийг тэд сайн ойлгож авчээ. Учир нь зургаан сар болоод 100 кг хүрч борлуулах боломжтой гэж тооцон худалдаж авсан гахай нь үүлдэр угсаа холилдсон байсан учраас зургаан сарын дараа борлуулахаар хэмжээнд томорч чадаагүй байна.

Гахайг авсан даруйдаа маллагаа, арчилгааны мэргэжлийн сургалтад суух хэрэгтэй. Арчилгаа маллагаа, хоолны горим алдагдсанаар гахайн ашиг шим буурах, нялх торой үхэх зэрэг эрсдэл үүсдэг байна.

Зориулалтын байрыг нь барьсан хойноо гахайг худалдаж авах хэрэгтэй. Тэгэхгүй бол нялх торой дарагдаж үхэх, осгож үхэх зэрэг эрсдэлтэй байдаг байна.

Орон нутаг болон ТБУТ-аас авсан дэмжлэг

Орон нутгийн удирдлагууд бичил уурхайчдыг дэмжиж, гахайн байр барих газрын зөвшөөрлийг шийдэж өгчээ.

ТБУТ-өөс 5.0 сая төгрөгийн жижиг бизнесийн төслийн санхүүжилт авч, гахайн өвлийн байраа барьснаар гахайн аж ахуйгаа жилийн дөрвөн улиралд тасралтгүй үргэлжлүүлэх боломжтой болсон байна.

Түүнчлэн гахайн аж ахуйн технологийн сургалт, бизнес төслийн сургалт, санхүүгийн тайлан гаргах сургалтуудад ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр хамрагджээ. Ингэж гахайн аж ахуйн сургалтад сууснаар шинээр барьсан өвлийн байраа барихдаа багш нараас нь зөвлөмж авч, гахайг хэрхэн хооллох, маллах, арчлах талаар мэдлэгээ нэмэгдүүлсэн байна.

Бизнес төслийн сургалтад сууснаар аж ахуйн орлого, зардлаа тооцох, эдийн засгийн үр ашгийг нь оновчтой тогтоох, гишүүд бүгд хөрөнгө оруулалтаасаа ямар хэмжээний ашгийг хэзээ олох боломжтойгоо мэдэж авах гэх мэт олон талын мэдлэг, мэдээлэлтэй болжээ. Санхүүгийн тайлан гаргах, санхүүгийн үйл ажиллагаагаа цаашид хөтлөн явуулах мэдлэгтэй, санхүүгийн үйл ажиллагааны дүрэм журамтай болсноор хоршооны санхүүгийн ил тод, хариуцлагатай байдал сайжирч, гишүүд хоорондын итгэлцэл, ойлголцолд эерэгээр нөлөөлсөн ба цаашид хамтран ажиллах, хоршооны тогтвортой байдалд сайнаар нөлөөлсөн байна.

Ирээдүйн төлөвлөгөө

“9 найзууд” хоршооныхон цаашид гахайн аж ахуйгаа өргөжүүлэхийн тулд банк санхүүгийн байгууллагуудаас нэмэлт санхүүжилт татах, үүний тулд санхүүгийн тайлангаа зохих журмын дагуу тогтмол гаргаж явахаар төлөвлөж байна.

Гахай маллах болон фермерийн аж ахуй эрхлэх чиглэлээр тус хоршооны гишүүн Ж.Мөнх-Эрдэнэ, Н.Туул, М.Мөнхбаатар, З.Цэцэгсүрэн, Х.Шинэбат, Э.Гансүх нар Заамар сумын МСҮТ-д суралцаж байна. Тэд үйл ажиллагаагаа улам өргөжүүлэн үхэр, тахиа, галуу тэжээж, туслах аж ахуйн цогцолбор байгуулах зорилготой ажиллах болжээ.

Гахайгаа өсгөж, сүргийн эргэлтээ тогтворжуулан, сар бүр тогтмол 10 гахай зах зээлд нийлүүлдэг болгож тохируулахаар ажиллаж байгаа аж.

ЗААМАР НУТГИЙН ХӨГЖИЛД БИДНИЙ ОРОЛЦОО ТББ

Төв аймгийн Заамар сумын Заамар нутгийн хөгжилд бидний оролцоо ТББ-ын гишүүд 2014 онд сум орон нутагтаа 1.7 сая төгрөгийн хандив, тусламж үзүүлсэн ба 2015 оноос зарим гишүүд нь жижиг, дунд бизнес эрхэлж эхлээд байна.

Төмс, хүнсний ногооны тариалалт

Тус ТББ-ын гишүүн бичил уурхайчдыг бичил уурхайгаас өөр, тогтмол орлогын эх үүсвэртэй болох чиглэлээр санаачилга гаргасныг нь орон нутгийн удирдлагууд дэмжиж 4x8 хэмжээтэй нарийн ногооны хүлэмж, бүрэн усалгааны системтэй нь өгсөн төдийгүй, Заамар сумын 4 дүгээр багийн, 5 дугаар хэсгийн 10-3 тоотод 1,800 м² эзэмшлийн газар олгожээ. Бичил уурхайчид энэхүү талбай дээрээ ТБУТ-ийн санхүүжилтээр хашаа барьж, тариалсан ногоогоо мал амьтнаас хамгаалах боломжтой болсон байна.

Энэ жил л гэхэд тус ТББ-ын бичил уурхайчид ногооны задгай талбай болон хүлэмждээ төмс, лууван, байцаа, манжин, сонгино, өргөст хэмх, улаан лооль тариалж, жилдээ 7.2 сая төгрөгийн орлого олж, ТББ-ын 30 гишүүн тус бүрд 240.0 мянган төгрөг хуваарилахаар төлөвлөн ажиллажээ.

Орон нутагт оруулсан хувь нэмэр

Хандив тусламж:

2014 онд Заамар сумын Өл, Цагаанчулуут хэмээх газруудад Заамар нутгийн хөгжилд бидний оролцоо ТББ-ын “Нутгийн хөгжил” нөхөрлөл 25 гишүүнтэйгээр дөрвөн сар ажиллаж, нийт 1.5 кг алт буюу 91 сая төгрөгийн ажил хийж, хүн тус бүр 3.8 сая төгрөгийн ашигтай ажилласан ба сум орон нутагтаа нийт 1.7 сая төгрөгийн хандив, тусламж өгсөн байна.

- СХС-д 500.0 мянган төгрөг.
- Дотуур байрны тасаг тохижуулж, тоглоом авахад зориулан 500.0 мянган төгрөг.

- ЕБС-ийн 20 хүүхдэд хичээлийн иж бүрэн хэрэгсэл, цүнхтэй авч өгөхөд 500.0 мянган төгрөг.
- Сумын төв дээр зохиогдсон “Оюутан” өдөрлөгт 200.0 мянган төгрөг.

Ирээдүйн төлөвлөгөө

Азийн сангийн нөхөн сэргээлтийн БОХТОН-II төсөлд ирэх онд хамрагдахаар төлөвлөн бэлтгэлээ хангаж байна.

Мөн ТБУТ-ийн санхүүжилтээр хашаажуулсан талбайдаа ногоо тарих, цаашид бичил уурхайчдаа нэгтгэн төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж өрхийн орлогоо бүрдүүлдэг болох зорилттойгоор ажиллаж байна.

ТББ-ын танилцуулга

Заамар нутгийн хөгжилд бидний оролцоо ТББ-ыг 2013 оны дөрөвдүгээр сарын 21-нд 30 бичил уурхайчин хамтран байгуулжээ. Гишүүдийн 20 нь эрэгтэй, 10 нь эмэгтэй бичил уурхайчин байна.

УЗ-ийн бүрэлдэхүүн

1. Ж.Мөнхтуяа
2. А.Пүрэвсүрэн
3. Б.Сайханжаргал
4. Ж.Уранчимэг

ХЗ-ийн бүрэлдэхүүн

1. Н.Баярмаа
2. З.Дамбадаржаа
3. Л.Саранцэцэг

МБУНДХ-ны УЗ-д Ш.Батгэрэл, ХЗ-д Н.Баярмаа нар байдаг.

Тус ТББ гишүүн бичил уурхайчдаа төрөл бүрийн сургалт зөвлөгөөнд хамруулж, чадавхижуулахад ихээхэн анхаарч ажилладаг.

- Аврах албаны сургалтад хоёр бичил уурхайчин суралцав.
- Соёмбо академид зургаан бичил уурхайчин суралцав.
- Улс төр менежментийн академид долоон бичил уурхайчин суралцав.
- НДЕГ-аас зохион байгуулсан сургалтад нэг бичил уурхайчин суралцав.
- Санхүү бизнесийн дотоод журам, хурал зохион байгуулах сургалтад 21 бичил уурхайчин суралцав.
- Хөгжлийн Шийдэл ТББ-ын зохион байгуулсан бизнес төслийн сургалтад зургаан бичил уурхайчин суралцав.
- МСҮТ-ын ойжуулагчийн ангийг 10 хүн сертификаттай, таван хүн мэргэжлийн үнэмлэхтэй төгсөв.
- Эдийн засаг Үндэсний дээд сургуульд хоёр хүн суралцав.

Мөн гишүүдээ өөр ажил, бизнестэй болоход нь тал бүрээр дэмжиж ажиллаж байна. Тухайлбал:

- MNO буюу Уул уурхайн үндэсний олборлогч компанид найман гишүүнийхээ өргөдөл бичиг баримтыг бүрдүүлэн өгч, ярилцлагад оруулснаас нэг бичил уурхайчин байнгын ажлын байртай болсон байна.
- Заамар сумын СХС-ийн зээлд гурван бичил уурхайчныг, малжуулах төсөлд нэг бичил уурхайчныг, оюутны төлбөрийн хөнгөлөлтөд нэг бичил уурхайчныг тус тус хамруулсан байна.

2014 онд ШХА-ийн ТБУТ-ийн жижиг төсөлд оролцож ТББ-ын гишүүдийг чадавхижуулах, ТББ-аа сурталчлах, туршлагатай багш нараас сургалт авах, ТББ-ын гишүүдийн дунд АХА тэмцээн, гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулах зэрэг ажлуудыг хийсэн. Өл, Цагаан Чулуут зэрэг газруудад олборлолт хийж байсан найман нөхөрлөлийг хамруулсан бичил уурхайчдын өдөрлөг зохион байгуулсан байна.

ЭХ ОРОН ХАМТЫН ХҮЧ ТББ

Дорноговь аймгийн Айраг сумын Эх орон хамтын хүч ТББ-ын гишүүн бичил уурхайчид албан ёсны зохион байгуулалтад орсон цагаасаа эхлэн сум орон нутгийнхаа нийгэм, эдийн засагт илэрхий нэмэр оруулж эхэлсэн ба 2015 оны байдлаар татвар, НД, хандив тусламж хэлбэрээр 27.7 сая төгрөгийн шууд хувь нэмэр оруулсан байна.

Мөн тус ТББ-ын гишүүн бичил уурхайчид талх нарийн боовны цех, цайны газар, үнээний ферм, үсчин гоо сайхны газар, блокны үйлдвэрийн бизнес эрхэлж байна.

Бизнесийн бусад үйл ажиллагаа

Бизнес эрхэлж байгаа болон төсөл хөтөлбөрт хамрагдсан гишүүд, нөхөрлөлүүдийг доор жагсаалаа.

1. “Дэвжих” нөхөрлөлийн Ц.Одонтуяа нарын таван бичил уурхайчин талх нарийн боовны цех ажиллуулж байна.
2. “Гурван гал” нөхөрлөлийн Б.Баяраа нарын таван бичил уурхайчин цайны газар ажиллуулж байна.
3. “Баян-Өв” нөхөрлөлийн Э.Эрдэнэчимэг нарын таван бичил уурхайчин сүүний үхрийн аж ахуй эрхэлж байна.
4. “Ачтан” нөхөрлөлийн Б. Саранчимэг нарын гурван бичил уурхайчин мөн цайны газар ажиллуулж байна.
5. “Цагаан дэл-1” нөхөрлөлийн гурван бичил уурхайчин үсчин гоо сайхны газартай болсон байна.
6. “Дэлгэрэх” нөхөрлөлийн Б.Цог-Юурин нарын гурван бичил уурхайчин блок үйлдвэрлэж байна.

Орон нутагт оруулсан хувь нэмэр

ХАОАТ

Эх орон хамтын хүч ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2015 оны байдлаар улсын төсөвт 1.4 сая төгрөгийн татвар төлсөн байна.

НД-ын шимтгэл:

Эх орон хамтын хүч ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2015 оны байдлаар НД-ын санд 3.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ЭМД шимтгэл:

Эх орон хамтын хүч ТББ-ын гишүүн 70 бичил уурхайчин 2015 оны байдлаар ЭМД-ын санд 562.0 мянган төгрөгийн шимтгэл төлсөн байна.

Хандив тусламж, нийгэмд тустай үйлс:

1. Айраг сумын 90 жилийн ойн баярыг тохиолдуулан сумын гэрэлт цамхгийн гэрэлтүүлгийг Ч.Батбаяр ахлагчтай Арвин баялаг нөхөрлөл 2.5 сая төгрөгөөр бүтээн байгуулж орон нутагт хүлээлгэн өгсөн.
2. Ц. Одонтуяа ахлагчтай Дэвжих Нөхөрлөл Айраг 90 жил гэрэлт чимэглэлийг 600.0 мянган төгрөг зарцуулан, өөрсдөө хийж хандивласан.
3. Говь нутгийн чулуухоршоо Айраг сумын дурсгалын баганыг сэргээн засварлаж хагас үнэт чулуугаар өнгөлсөн.
4. М. Алтангэрэл ахлагчтай Баялаг жонш нөхөрлөл Хөл бөмбөгийн талбайг сэргээн засах ажилд одоогоор 2.3 сая төгрөг зарцуулсан байна. 2016 онд бүрэн засварыг хийж гүйцэтгээд орон нутагт хүлээлгэж өгөх зорилт тавин ажиллаж байна
5. М. Алтангэрэл ахлагчтай Баялаг жонш нөхөрлөл 2014 оны Айраг сумын хөл бөмбөгийн аварга шалгаруулах 10 дахь удаагийн тэмцээнийг зохион байгуулж, шагналын сангийн 1.5 сая төгрөгийг ивээн тэтгэсэн.
6. Ч.Батбаяр ахлагчтай Арвин баялаг нөхөрлөл хүүхдийн цэцэрлэгийн бага ангид өнгөт зурагт, Онцгой байдлын газарт 1.0 сая төгрөгийн үнэ бүхий дэлгэц хандивлав.
7. М. Алтангэрэл ахлагчтай Баялаг жонш нөхөрлөл Одонтой ээжүүд баярын арга хэмжээг 350.0 мянган төгрөгөөр ивээн тэтгэсэн.

8. Н.Батжаргал ахлагчтай Талст нөхөрлөл 90 жилийн ойн хурдан морины уралдааны бай шагналд 1.0 сая төгрөг хандивласан.
9. Ч.Батбаяр ахлагчтай Арвин баялаг нөхөрлөл авьяаслаг Айрагчууд тоглолтыг 300.0 мянган төгрөгөөр, гэр бүлийн өдрийн арга хэмжээг 300.0 мянган төгрөгөөр тус тус ивээн тэтгэсэн.
10. Нутгийн сайхан ээжүүд чуулганы ерөнхий зохион байгуулагчаар ажилласан.
11. ТББ-ын нөхөрлөлүүд өөрийн машин техникийг дайчлан Айраг суманд хуримтлагдсан хур хогийн цэвэрлэхэд 10 хоногийн үнэгүй турш ажилласан.
12. Айраг суманд шүлхий гарсан үеэр хоёр сарын турш ТББ-ын нөхөрлөлүүд өөрийн техникээр халдварт өвчний тархалтыг зогсоохын тулд хийсэн устгалын ажилд тусалсан.

Ирээдүйн төлөвлөгөө

Өнгөт чулуугаар гоёл чимэглэлийн зүйлс үйлдвэрлэн Улаанбаатар хотын зах зээлийг бүрэн хангах, үндэсний брэнд бүтээгдхүүн болгож хөгжүүлэх төглөвлөгөөтэй ажиллаж байна.

Айраг сумандаа бичил уурхайчдын өдрийг бий болгон, жил бүр тогтмол өдөрлөг зохион байгуулж, тайлангаа тавьж байх санаачилга гаргаад байна.

Олборлолт хийж дууссан газрууддаа нөхөн сэргээлт хийх ажилд лонцгойлон анхаарч байна.

Олборлолтын талбайд стандартын дагуу бичил уурхайчдын суурьшлын бүс байгуулах.

Сумын Засаг дарга, Хөх төр ХХК-тай гурван талт хэлэлцээр байгуулах.

ТББ-ын танилцуулга

Айраг сумын бичил уурхайчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр 2009 оноос идэвхтэй ажиллаж ирсэн бичил

уурхайчдын төлөөлөл болсон хүмүүс 2010 оны зургадугаар сард Эх орон хамтын хүч ТББ болон зохион байгуулагдсан юм.

Одоогийн байдлаар 25 гишүүн нөхөрлөл, Говь нутгийн чулуу хоршоог эгнээндээ нэгтгэн, нийт 110 бичил уурхайчны гишүүнчлэлтэй болон өргөжин тэлж, хариуцлагатай бичил уурхайн нөхөрлөлүүдийг төлөвшүүлэхэд анхааран ажиллаж байна.

ТББ-ын гишүүн нөхөрлөлүүд орон нутгаас зөвшөөрөгдсөн гурван газарт 2016 онд гэрээ байгуулан ажиллахаар бэлтгэл хангаж, өөр гурван газарт уул уурхайн компанитай гурван талт гэрээ байгуулан, жоншгы олборлолт хийж байна.

УЗ-ийн гишүүдээс Л.Лхагва, Ц.Батдэлгэр, Б.Цог-Юурин, нөхөрлөлийн ахлагч Н.Батжаргал, хоршооны гишүүн Д.Баяраа, Х.Өлзийбат нарын зургаан хүн орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж орон нутгийн нийт иргэдийн төдийгүй бичил уурхайчдынхаа эрх ашгийг төлөөлж байна.

Тус ТББ-ын дотоод зохион байгуулалтын хувьд тэргүүн бөгөөд гүйцэтгэх захирал нэг, УЗ-ийн долоон гишүүн, ХЗ-ийн гурван гишүүн, гүйцэтгэх зөвлөлийн 23 гишүүн, нярав нэг, нягтлан бодогч нэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг.

ТББ-ын гишүүн нөхөрлөлүүд

1. “Талст” нөхөрлөл, ахлагч нь Н.Батжаргал, таван гишүүнтэй, олборлолтын талбай: Хайрт -2
2. “Арвин Баялаг” нөхөрлөл, ахлагч нь Ч.Батбаяр, долоон гишүүнтэй, олборлолтын талбай: Хайрт-1
3. “Баялаг жонш” нөхөрлөл, ахлагч М.Алтангэрэл, долоон гишүүнтэй, олборлолтын талбай: Бужгар
4. “Хүчин төгөлдөр” нөхөрлөл, ахлагч нь Я.Байгаль, таван гишүүнтэй, олборлолтын талбай: Алтад
5. “Алтад” нөхөрлөл, ахлагч нь Д.Алтанбагана, таван гишүүнтэй, олборлолтын талбай: Алтад
6. “Хатанболд” нөхөрлөл, ахлагч нь Төрбат, таван гишүүнтэй, олборлолтын талбай: Алтад

7. “Нутгийн ард” нөхөрлөл, ахлагч нь Д.Энхтөр, таван гишүүнтэй, олборлолтын талбай: Алтад
8. “Анд” нөхөрлөл, ахлагч нь Г.Эрхэмбаяр, таван гишүүнтэй, олборлолтын талбай: Хонгор
9. “Аагий баагий” нөхөрлөл, ахлагч нь Ц.Батдэлгэр, долоон гишүүнтэй, олборлолтын талбай: Хонгор
10. “Солонго” нөхөрлөл, ахлагч нь Ч.Цогтбаатар, таван гишүүнтэй, олборлолтын талбай: Бужгар
11. “Цагаан дэл” нөхөрлөл, ахлагч нь Б.Баярт, таван гишүүнтэй, олборлолтын талбай: алтад
12. “Нутгийн ард” нөхөрлөл, ахлагч нь Ц.Төрмөнх, таван гишүүнтэй, олборлолтын талбай: Алтад
13. “Алтан Ундарга” нөхөрлөл, ахлагч нь Болдбаатар, гурван гишүүнтэй, олборлолтын талбай: Алтад

ТББ-ын хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд

1. 2010 онд ШХА-ийн ТБУТ-ийн жижиг төсөлд хамрагдаж ТББ-аа чадавхжуулах ажлуудыг зохион байгуулсан.
2. 2011 онд Алтан ундарга нөхөрлөл ШХА-ийн ТБУТ-ийн жижиг төсөлд хамрагдаж суурьшлын бүсээ тохижуулсан.
3. 2012 онд ТБУТ-ийн дэмжлэгээр өнгөт чулуугаар бэлэг дурсгалын зүйл хийх Говь нутгийн чулуу хоршоог байгуулсан.
4. 2013 онд Мерси корпс ОУ-ын байгууллагатай хамтран Хууль дүрэм бодит амьдралд төслийг бичил уурхайчид болон тэдний гэр бүлийн хүмүүсийг хамруулан хэрэгжүүлж Мерси Корпс-ын Зүүн өмнөд бүсийг хариуцсан байгууллагын ӨРГӨМЖЛӨЛ-өөр шагнуулсан.
5. 2014 онд ШХА-ийн ТБУТ-ийн санхүүжилтээр АНУ-ын Азийн сангаас хэрэгжүүлж буй БОХТОН-II төслөөр нөхөн сэргээлт хийсэн.
6. 2015 онд Алтайдын голд бичил уурхайн суурьшлын бүсийг ШХА-ийн ТБУТ-ийн 2.6 сая төгрөгийн санхүүжилтээр Баялаг жонш, Цагаан дэл, Нутгийн ард нөхөрлөлүүд хамтран гүйцэтгэсэн.

7. 2015 онд ШХА-ийн ТБУТ-ийн дэмжлэгээр Ноосон эдлэлийн гар урлалыг дэмжих төв ТББ-тай хамтран 20 бичил уурхайчныг ноосон эдлэлийн гар урлалын сургалтад хамруулсан.

БАЯН РАШААНТ НУТАГ ТББ

Говь-Алтай аймгийн Баян рашаант нутаг ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2013-2015 оны хооронд татвар, НД, хандив тусламж хэлбэрээр орон нутагтаа 57.4 сая төгрөгийн шууд хувь нэмэр оруулжээ.

Мөн сум орон нутгийнхаа олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцдог төдийгүй сүүлийн жилүүдэд нөхөн сэргээлтийн төсөлд хамрагдаж бичил уурхайгаар сүйтгэгдээд байсан 61.75 га талбайг нөхөн сэргээж, нийгмийн хариуцлагын ажлын хүрээнд аймгийнхаа төвд 320 мод тарьсан байна.

Ариун эрдэнэ солонго ХЗХ

Баян рашаант нутаг ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2015 оны тавдугаар сард ТБУТ-ийн дэмжлэгээр ХЗХ-ны тухай сургалтад хоёр удаа хамрагдсан юм. Ингээд 22 гишүүн бичил уурхайчин сайн дураараа нэгдэж Ариун эрдэнэ солонго ХЗХ-г үүсгэн байгуулаад байна. Эхний байдлаар тус бүр 100.0 мянган төгрөг гаргаж 2.2 сая төгрөгийн хуримтлал үүсгэн ажиллаж эхэлжээ.

Цаашид Баян рашаант нутаг ТББ-ын гишүүн бичил уурхайчид зөвхөн бичил уурхайн салбарт төдийгүй санхүүгийн салбарт хамтран ажиллахаар төлөвлөж байна. Тэд одоогийн байдлаар гэрчилгээ, тамга тэмдгээ аваад байгаа ба Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө хүлээж байна.

Тус ХЗХ нь гишүүддээ хадгаламжийн болон зээлийн үйлчилгээнээс гадна санхүүгийн бусад үйлчилгээг үзүүлэх төлөвлөгөөтэй байгаа юм. Бичил уурхайчид хуримтлал үүсгэж бичил уурхайгаас өөр салбарт жижиг, дунд, бичил бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой болох юм.

ХЗХ байгуулснаар гарах үр дүн:

- Байнгын үйл ажиллагаа явуулах учир хамт олон идэвхжинэ.
- Гишүүн бүр хуримтлалтай болно.

- Гишүүд хамтарч бизнес эрхлэхэд санхүүгийн дэмжлэгтэй болно.
- Гишүүд өөрсдийн зээлийн эрэлт хэрэгцээгээ хурдан шуурхай шийдвэрлүүлнэ.
- Гишүүдийн эдийн засгийн боловсрол дээшилнэ.
- Ажлын байр нэмэгдэнэ, амьжиргааны төвшин дээшилнэ.

Орон нутагт оруулсан хувь нэмэр

ХАОАТ:

Баян рашаант нутаг ТББ-ын гишүүд өнгөрсөн гурван жилийн хугацаанд 9.9 сая төгрөгийн ХАОАТ төлсөн байна. Энэ мөнгө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр таван хүний 12 сарын цалинг өгөхөд хүрэлцэнэ.

	Он	Татварын дүн
1	2013	1,320,000
2	2014	7,750,000
3	2015	850,000
	Нийт	9,920,000

НД-ын шимтгэл:

Мөн тус ТББ-ын гишүүн бичил уурхайчид 2013-аас 2015 оны хооронд 43.2 сая төгрөгийг НД-ын санд төвлөрүүлжээ. Энэ мөнгөөр НД-аас жирэмсэн эхчүүдэд нэг удаа олгодог тэтгэмжийг 112 хүнд өгч болно.

ЭМД-ын шимтгэл:

Баян рашаант нутаг ТББ-ын гишүүн бичил уурхайчид мөн 2013-2015 оны хооронд ЭМД-ын санд 4.3 сая төгрөгийн шимтгэл төлсөн байна.

Аймгийн төвийн нэгдсэн эмнэлгүүдэд ЭМД-ын сангаас нэг хүнд зарцуулсан мөнгөн дүн ойролцоогоор 35.0 мянган төгрөг байдаг гэж тооцвол бол бичил уурхайчдын төлсөн шимтгэл 124 хүнд хүрэлцэх юм.

Нийгэмд тустай үйлс:

Баян рашаант нутаг ТББ нь жил бүр аймгийнхаа төвд мод тарьдаг сайхан уламжлал тогтоогоод байна. Тухайлбал,

- 2013 онд – 180 ш мод
- 2014 онд - 60 ш мод
- 2015 онд - 80 ш мод

гэх мэт гурван жилийн хугацаанд нийт 320 ширхэг мод тарьсан байна. Нэг мод жилд 260 кг хүчил төрөгч ялгаруулдаг гэвэл Говь-Алтайчуудад жил бүр 83,200 кг хүчилтөрөгч бэлэглэж чадахаар болжээ.

Мөн ТББ-ын гишүүд хот тохижуулах /хог цэвэрлэх, зам засах/ гэх мэт нийгэм олон нийтэд тустай ажилд цалингүй оролцож хүч хөдөлмөрөөрөө орон нутгийнхаа хөгжилд хувь нэмэр оруулдаг.

Ирээдүйн төлөвлөгөө

Ариун эрдэнэ солонго ХЗХ нь Говь-Алтай аймагтаа анхных болж байгаа учраас өөр бусад бичил уурхайн ТББ-уудаас үйл ажиллагаа нь эхэлсний дараа хамрагдъя гэсэн хүсэлт гаргаж байгаа 40 гаран бичил уурхайчин байна.

Мөн өөр бусад тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай бичил уурхайчин бус хүмүүс ч гэсэн хандаж байна. Тиймээс ХЗХ-ныхоо дүрмийн санг 1 тэрбум төгрөгт хүргэн үйл ажиллагааг өргөжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Түүнчлэн ТББ гишүүн бичил уурхайчдаа цаашид мэдлэг ур чадварт нь тохирсон жижиг дунд бизнес эрхлэх чиглэлээр дэмжиж ажиллахаар зорьж байна. Тухайлбал, Монгол гутал үйлдвэрлэдэг бичил уурхайчдынхаа бизнесийг өргөжүүлэхээр төлөвлөж байна.

ТББ-ын танилцуулга

2013 оны 10 дугаар сарын 20-нд байгуулагдсан анх таван нөхөрлөлийн 42 гишүүнтэйгээр Баян рашаант нутаг ТББ байгуулагджээ.

ТББ-ын удирдлага зохион байгуулалт, бодлогыг УЗ-ийн таван гишүүн, ХЗ-ийн гурван гишүүн, тэргүүн нар хариуцан бичил уурхайчдынхаа эрх ашгийг хамгаалахын төлөө ажиллаж байна.

Тус ТББ байгуулагдсан цагаасаа эхлэн төсөл хөтөлбөрүүдэд хамрагдаж сумын нутаг дэвсгэрт хувиараа ашигт малтмал олборлогчдын гараар эвдэж сүйтгэгдсэн газрыг нөхөн сэргээж явсан бөгөөд,

- 2013 онд – 10.1 га
- 2014 онд – 32.8 га
- 2015 онд - 12.1 га
- Нийт 61.7 га

газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн.

УЗ-ийн гишүүд:

1. Б.Бадамханд
2. Ш.Ганбат
3. Д.Мөнхбаатар
4. Ч.Пүрэвдорж
5. Ч.Оюунчимэг

ХЗ-ийн гишүүд:

1. И.Дамдин
2. Г.Түмэнтогтох
3. Г.Хосбаяр

Тэргүүн, гүйцэтгэх захирал: Ч.Оюунчимэг

ХОЛБОО БАРИХ:

Монгол Улс, Улаанбаатар хот,
Скай Плаза Бизнес төв,
Олимпийн гудамж 12,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо

Утас: +976 11 328848
Факс: +976 11 322415

И-майл: ulaanbaatar@sam.mn
Вэб хуудас: www.sam.mn
Facebook: ASM Mongolia
Twitter: ASM Mongolia

Энэхүү гарын авлагыг худалдахыг хориглоно.